

# АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГ ТОГТООХ СУДАЛГАА 2017



**The Asia Foundation**

Canada 



**The Asia Foundation**



Sant-Maral Foundation

Энэхүү судалгааг Канадын Засгийн газар, Канадын гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр хийсэн болно. Судалгааг Азийн Сан, Сант Марал сантай хамтран явуулсан бөгөөд судалгааны үр дүн нь Канадын Засгийн газар болон Канадын Гадаад хэргийн яамны үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

Хавтасны зургийг Гэрэл зурагчин Г.Батсайхан

# АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГ ТОГТООХ СУДАЛГАА

МОНГОЛ УЛСАД АРДЧИЛСАН ОРОЛЦООТОЙГООР ТӨРИЙН АЛБАНД  
САЙН ЗАСАГЛАЛ, ИЛ ТОД БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ

## АГУУЛГА

Агуулга .....	I
Хүснэгт, графикийн жагсаалт .....	II
Оршил.....	VII
Судалгааны гол үр дүн .....	VIII
1. Монгол Улсад тулгамдаж буй асуудлууд .....	14
2. Авлигын талаарх ойлголт, хандлага .....	18
3. Авлигын чиг хандлагын үнэлгээ .....	34
4. Өрхийн түвшний авлига болон хээл хахууль .....	40
5. Дээд түвшний авлига .....	48
6. Авлигад хамгийн их автсан байгууллагууд .....	56
7. Хээл хахууль хувь хүнд .....	60
8. Шударга хандлагын талаарх хүлээлт .....	66
9. 2017 оны сонгуулийн ил тод, шударга байдал .....	72
10. Авлигын шалтгаан .....	78
11. Авлигаас урьдчилан сэргийлэх.....	84
12. Авлигатай тэмцэх .....	90
13. Авлигатай тэмцэх газар .....	100
14. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл.....	106
15. Хүн ам зүй .....	110
Хавсралт: Судалгааны арга зүй .....	113

## ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1:	2017 оны 3 сар: Тулгамдаж буй гол асуудлууд .....	15
Зураг 1.2:	“Ажилгүйдлийг” гол тулгамдаж буй асуудал гэж үзэх хандлага (2006 - 2017 он) .....	15
Зураг 1.3:	“Авлигыг” гол тулгамдаж буй асуудал гэж үзэх хандлага (2006 - 2017 он).....	16
Зураг 1.4:	Ажилгүйдэл болон авлигыг тулгамдаж буй асуудал гэж үзсэн хандлага (2006 - 2017 он), Хүйсээр .....	16
Зураг 2.1:	Хувь хүний амьдрал, бизнесийн орчин, улс төрд авлигын үзүүлэх үр нөлөө .....	18
Зураг 2.2:	Авлигын үр нөлөө - 2016, 2017 онд .....	19
Зураг 2.3:	Манай улсад авлига нийтлэг зүйл болсон .....	19
Зураг 2.4:	Авлига тодорхой хэмжээнд байхыг хүлээн зөвшөөрнө.....	20
Зураг 2.5:	Өнөөгийн улс төрийн тогтолцоо авлигатай тэмцэхэд амжилт гаргасан .....	21
Зураг 2.6:	Иргэний нийгэм авлигаас урьдчилан сэргийлж чадна.....	21
Зураг 2.7:	Авлигаас урьдчилан сэргийлэхэд зөвхөн төрийн байгууллагууд тусалж чадна .....	22
Зураг 2.8:	Өнөөгийн нөхцөлд иргэний хөдөлгөөн, төрийн бус байгууллагууд авлигын эсрэг тэмцэх гол хүчин юм ..	22
Зураг 2.9:	Улс төрчид авлигаас ашиг олж болох учраас авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл байхгүй .....	23
Зураг 2.10:	Нийгэмд газар авсан хүнд суртлыг шийдэх ганц арга бол хээл хахууль өгөх .....	24
Зураг 2.11:	Хээл хахууль нь зарим үед шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг .....	24
Зураг 2.12:	Авлигаас болж том бизнесийнхнээс илүүтэйгээр жижиг, дунд бизнес эрхлэгчид хохирдог .....	25
Зураг 2.13:	Том бизнес эрхлэгчид авлигын гол эх үүсвэр болдог гэдэг тэй та санал нийлж байна уу?.....	26
Зураг 2.14:	Орон нутгийн захиргааны албан хаагчид ихэнхдээ итгэл үзүүлж болохуйц, хариуцлагатай хүмүүс байдаг .....	26
Зураг 2.15:	Авлигыг бууруулахад иргэд өөрсдөө хариуцлагатай байх ёстой .....	27
Зураг 2.16:	Шийдвэр гаргагчид өөрсдөө авлигаас төдийлөн хохирдоггүй, жирийн иргэд л авлигаас болж хохирч байна .....	28
Зураг 2.17:	Авлигын эсрэг хууль, тогтоомж үр дүнгүй байна .....	29
Зураг 2.18:	Төрийн албан хаагчид бага цалин авч байгаа нь хээл хахуулийн гол шалтгаан болдог .....	29
Зураг 2.19:	Төрийн албан хаагчид бага цалин авч байгаа нь хээл хахуулийн гол шалтгаан болдог (Хүйсээр) .....	30
Зураг 2.20:	Албан тушаалтнуудад хатуу ял шийтгэл оногдуулах нь авлигыг зогсооно.....	30
Зураг 2.21:	Хээл хахууль өгсөн хүн түүнийг авсан хүнтэй адил гэм буруутай.....	31

Зураг 2.22:	Авлигатай тэмцэх бодлогын хэрэгжилт улс төрийн сонирхол аг уулаагүй. ....	31
Зураг 3.1:	Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? .....	34
Зураг 3.2:	Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? (Төрийн байгууллагийн ажилтнууд).....	35
Зураг 3.3:	Өнгөрсөн гурван жилд Монголд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? (ТББ болон хувийн хэвшлийн ажилтнууд).....	35
Зураг 3.4:	Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ? .....	36
Зураг 3.5:	“Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ?” (Төрийн байгууллагийн ажилтнууд).....	37
Зураг 3.6:	“Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ?” (Хувийн болон ТББ-ууд).....	37
Зураг 4.1:	Сүүлийн 3 сарын хугацаанд Та болон танай гэр бүлийн гишүүд ямар нэгэн хэлбэрээр хээл хахууль өгсөн үү? (“Тийм” гэсэн хариулт).....	40
Зураг 4.2:	Хандив нь хээл хахууль уу эсвэл байгууллагын үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх нэг хэлбэр үү? .....	41
Зураг 4.3:	Авлига нь танай өрхийн төсөвт хэрхэн нөлөөлж байна вэ? .....	41
Зураг 4.4:	Амьдралын чанарын үнэлгээ (Эх сурвалж: СМС Улс төрийн Барометрийн мэдээлэл) .....	42
Зураг 4.5:	Дараах хүчин зүйлсийн аль нь сүүлийн 3 сард хахууль өгөх шалтгаан болсон бэ? .....	43
Зураг 4.6:	Дараах хүчин зүйлсийн аль нь сүүлийн 3 сард хахууль өгөх шалтгаан болсон бэ? (Хүйсээр дэлгэрэнгүй задалсан) .....	44
Зураг 4.7:	Өрхийн түвшний хээл хахуулийн талаарх статистик мэдээ.....	45
Хүснэгт 4-1:	Өрхийн түвшний хээл хахуулийн талаарх статистик мэдээ.....	45
Зураг 5.1:	Та дээд түвшний авлигын талаар ямар ойлголттой вэ? .....	48
Зураг 5.2:	Монголд дээд түвшний авлига ямар хэмжээнд байгаа вэ? .....	49
Зураг 5.3:	Таны бодлоор дээд түвшний авлига яагаад оршин байна вэ? (Олон сонголттой хариулт) .....	50
Зураг 5.4:	Дээд түвшний авлига танд болон танай гэр бүлд ямар нэгэн байдлаар сөрөг нөлөө үзүүлдэг гэж та бодож байна уу? .....	51
Зураг 5.5:	Хэрэв тийм бол танд эсвэл танай гэр бүлд ямар байдлаар нөлөөлж байна вэ? 2013 оны 3 сар .....	51
Зураг 5.6:	Хэрэв тийм бол танд эсвэл танай гэр бүлд ямар байдлаар нөлөөлж байна вэ? 2017 оны 3 сар.....	52
Зураг 5.7:	Та дээд түвшний авлигын талаар сонсож байсан бол, энэ нь ямар төрлийн авлига байсан бэ? (Олон сонголттой хариулт) 2013 оны 3 сар.....	52
Зураг 5.8:	Та дээд түвшний авлигын талаар сонсож байсан бол, энэ нь ямар төрлийн авлига байсан бэ?	

	(Олон сонголттой хариулт) 2017 оны 3 сар.....	53
Зураг 5.9:	Таны бодлоор дээд түвшний авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? 2013 оны 3 сар .....	53
Зураг 5.10:	Таны бодлоор дээд түвшний авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? 2017 оны 3 сар .....	54
Хүснэгт 6-1:	Авлигад хамгийн их автсан байгууллага, салбар .....	56
Зураг 6.1:	Авлигад хамгийн их автсан байгууллагууд, 2017 оны 3 сар .....	57
Зураг 6.2:	Авлигад хамгийн их автсан гурван салбар, байгууллага, 2017 оны 3 сар.....	58
Зураг 6.3:	Авлигад автсан бусад салбар, байгууллагууд, 2017 оны 3 сар (Судалгаанд оролцогчдын дурдсан тоо хэмжээ) .....	58
Зураг 7.1:	Хэрвээ танаас төрийн байгууллагын ажилтан эсвэл хувийн хэвшлийн ажилтан хээл хахууль өгөхийг шууд шаардсан тохиолдолд та юу хийх вэ? .....	60
Зураг 7.2:	Хэрвээ танаас төрийн байгууллагын ажилтан эсвэл хувийн хэвшлийн ажилтан хээл хахууль өгөхийг шууд шаардвал та юу хийх вэ? (2017 оны 3 сар, хүйсээр) .....	61
Зураг 7.3:	Хэрвээ танаас төрийн байгууллагын ажилтан эсвэл хувийн хэвшлийн ажилтан хээл хахууль өгөхийг шууд шаардсан тохиолдолд та юу хийх вэ? (2017 оны 3 сар, насны бүлгээр) .....	61
Зураг 7.4:	Хэрэв мэдээлэл өгөх бол хаана хандах вэ? .....	62
Зураг 7.5:	Хэрвээ та ашиг сонирхолын зөрчлийн талаар мэдвэл аль нэг газарт мэдэгдэх үү? .....	63
Зураг 7.6:	Таны бодлоор төрийн байгууллагын ажилтнууд хэр их ашиг сонирхолын зөрчил гаргадаг вэ? .....	63
Зураг 7.7:	Хэрэв та ашиг сонирхолын зөрчлийг мэдэгдэх бол хаана хандах вэ? 2017 оны 3 сар .....	64
Хүснэгт 8-1:	Төрийн байгууллагуудад итгэх итгэл, 2017 оны 3 сар (Эх сурвалж: СМС Улс төрийн барометр) .....	67
Хүснэгт 8-2:	Төрийн байгууллагуудад итгэх итгэл, 2010 оны 4 сар (Эх сурвалж: СМС Улс төрийн барометр) .....	67
Зураг 8.1:	Шударга хандлага: Боловсролын салбар.....	67
Зураг 8.2:	Шударга хандлага: Эрүүл мэндийн салбар.....	68
Зураг 8.3:	Шударга хандлага: Шүүхийн тогтолцоо .....	68
Зураг 8.4:	Шударга хандлага: Хууль сахиулах байгууллага .....	69
Зураг 8.5:	Шударга хандлага: Орон нутгийн захиргаа .....	69
Зураг 8.6:	Шударга хандлага: Засгийн Газар .....	70
Зураг 8.7:	Шударга хандлага (хүйсээр).....	70
Зураг 9.1:	Сонгуулийн бэлтгэл, Жишээ нь: Сонгогчдыг бүртгэх, сонгуулийн хороод болон	

	ажилтнуудыг бэлтгэх, гадаад дотоодын ажиглагчдыг оролцуулах гэх мэт.....	72
Зураг 9.2:	Сонгуулийн санхүүжилт .....	73
Зураг 9.3:	Сонгуулийн сурталчилгаа .....	73
Зураг 9.4:	Санал хураах байранд саналыг тоолох үйл явц.....	74
Зураг 9.5:	СЕХ-ноос сонгуулийн дүнг нэгтгэж, олон нийтэд танилцуулах үе.....	74
Зураг 9.6:	Сонгуулийн шударга байдал: хариулаагүй, хүйсээр.....	75
Зураг 10.1:	Авлигын үндсэн шалтгаан (дундаж утга) .....	78
Зураг 10.2:	Төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үр чадвар муу.....	79
Зураг 10.3:	Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад улс орны түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй .....	80
Зураг 10.4:	Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад орон нутгийн түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй .....	80
Зураг 10.5:	Хүндрэлтэй асуудлыг хууль дүрмийн дагуу бус хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл болсон.....	81
Зураг 10.6:	Хууль сахиулах байгууллагын хүрээнд авлига газар авсан .....	81
Зураг 10.7:	Олон нийтийн идэвхгүй байдал.....	82
Зураг 10.8:	Авлигатай тэмцэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, хүлээлгэх ял шийтгэл боловсронгуй биш.....	82
Зураг 11.1:	Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх ёстой вэ? .....	84
Зураг 11.2:	Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх ёстой вэ? 2017 оны 3 сар .....	85
Зураг 11.3:	2006 онд Авлигын эсрэг шинэ хууль батлагдсан. Та энэ хуулийн хүрээнд аль нэг албан тушаалтан шийтгүүлсэн тухай сонссон уу?.....	86
Зураг 11.4:	Авлигатай Тэмцэх Газарт авлигын талаар мэдүүлэх утас ажиллаж байгааг та мэдэх үү? .....	86
Зураг 11.5:	Хэрвээ Авлигатай Тэмцэх Газар нэр хаяггүй мэдээлэл хүлээж авна гэвэл та авлигын талаар мэдээлэл өгөх үү?.....	87
Зураг 12.1:	Таны бодлоор Авлигатай Тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (Эхний 5 үзүүлэлт) .....	90
Зураг 12.2:	Таны бодлоор одоогийн Засгийн Газар өмнөх Засгийн Газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ? (2010 – 2017 он).....	91
Зураг 12.3:	Таны бодлоор одоогийн Засгийн Газар өмнөх Засгийн Газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэх вэ? (2006 – 2017 он).....	91
Зураг 12.4:	Шилэн дансны тухай хууль нь хэр ач холбогдолтой вэ? .....	92



Зураг 12.5:	Шилэн дансны тухай хууль нь хэр үр дүнтэй байна вэ? .....	93
Зураг 12.6:	Бүргэлийн цахим машин, Нэг цонхны үйлчилгээ гэх мэт нь хэр чухал байна вэ? .....	94
Зураг 12.7:	Бүртгэлийн цахим машин, Нэг цонхны үйлчилгээ гэх мэт нь хэр үр дүнтэй байна вэ? .....	94
Зураг 12.8:	Төрийн албан хаагчдаас тогтмол гаргуулж авдаг орлогын мэдүүлэг нь хэр ач холбогдолтой байна вэ? ...	95
Зураг 12.9:	Төрийн албан хаагчдаас тогтмол гаргуулж авдаг орлогын мэдүүлэг нь хэр үр дүнтэй байна вэ? .....	96
Зураг 12.10:	Нэг цонхны үйлчилгээний төвүүд хэр ач холбогдолтой байна вэ? (2017 оны 3 сар).....	97
Зураг 12.11:	Нэг цонхны үйлчилгээний төвүүд хэр үр дүнтэй байна вэ? (2017 оны 3 сар).....	97
Зураг 12.12:	2016 оны 11 сард Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсаныг та мэдэх үү?.....	98
Зураг 13.1:	Авлигатай Тэмцэх Газрын үйл ажиллагааг та хэрхэн үнэлж байна вэ? .....	100
Зураг 13.2:	Авлигатай Тэмцэх Газрын үйл ажиллагааг та хэрхэн үнэлж байна вэ? 2017 оны 3 сар.....	101
Зураг 13.3:	Авлигатай Тэмцэх Газарт та хэр зэрэг итгэдэг вэ? .....	102
Зураг 13.4:	Авлигатай Тэмцэх Газарт Та хэр зэрэг итгэдэг вэ? 2017 оны 3 сар.....	103
Зураг 13.5:	Та Авлигатай Тэмцэх Газар бие даасан, аль нэг улс төрийн хүчнээс хамааралгүй үйл ажиллагаа явуулж чаддаг гэдэгт итгэдэг үү? .....	103
Figure 14.1:	Авлигын талаарх голлох мэдээллээ Та аль эх сурвалжаас авдаг вэ? (Зөвхөн нэг хариултыг сонгоно) .....	106
Зураг 14.2:	Хэрэв телевизийн суваг мэдээллийн голлох эх сурвалж бол, авлигын талаар хамгийн их мэдээлдэг сувгийг нэрлэнэ үү? (зөвхөн нэг хариултыг сонгоно) .....	107
Зураг 14.3:	Хэрэв Интернет эсвэл Нийгмийн сүлжээ мэдээллийн голлох эх сурвалж бол, авлигын талаар хамгийн их мэдээлдэг эх сурвалжийг нэрлэнэ үү? .....	108
Зураг 15.1:	Судалгаанд оролцогчид, хүйсээр, 2017 оны 3 сар .....	110
Зураг 15.2:	Судалгаанд оролцогчид, насны бүлгээр, 2017 оны 3 сар .....	111
Зураг 15.3:	Судалгаанд оролцогчид, боловсролын түвшинээр, 2017 оны 3 сар.....	111
Зураг 15.4:	Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, 2017 оны 3 сар.....	112
Хүснэгт А.	Түүврийн тархалт .....	114

## ОРШИЛ

Азийн сан, Сант Марал сантай хамтран Авлигын Талаарх Олон Нийтийн Ойлголт Мэдлэг тогтоох (SPEAK) 18 дахь удаагийн судалгааг нийслэл Улаанбаатар хот болон аймаг, сумдыг хамруулан үндэсний хэмжээнд 2017 оны 6 дугаар сард хийж гүйцэтгэлээ. Судалгаагаар авлигын цар хүрээ, олон нийтийн ойлголт, төсөөлөл, тэдгээрт гарч буй өөрчлөлт, өрхийн түвшиний авлигын тохиолдол, төр засгаас авлигын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг цуглуулж, ил болгохыг зорьдог.

Энэхүү судалгааг Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр Азийн сангийн хэрэгжүүлж буй Ардчилсан оролцоотойгоор Төрийн Албанд Сайн Засаглал, Ил тод Байдлыг Бэхжүүлэх нь төслийн (STEPS) хүрээнд явуулж байна. Судалгаа 2006-2011 оны хооронд АНУ-ын ОУХА-ийн санхүүжилтээр “Монгол дахь Авлигын түвшинг тогтоох” нэрээр хагас жил тутам хийгддэг байсан бол 2012 оноос “Авлигын Талаарх Олон Нийтийн Ойлголт Мэдлэг Тогтоох” судалгаа буюу SPEAK гэж нэрлэгдэх болсон. Тус судалгаагаар авлига, өндөр түвшний авлига, төрийн байгууллагууд дахь авлигын талаарх олон нийтийн ойлголт, төсөөлөл, мэдлэг болон өрхийн түвшин дэх авлигын тохиолдол, түүний үр нөлөөг судлахыг зорьдог юм.

STEPS төсөл үргэлжлэх хугацааны туршид энэхүү судалгааг гурван удаа явуулна. Судалгааны үр дүнгүүд нь төсөл боловсруулах, мэдээлэл цуглуулах болон төслийн бусад үе шатуудад баримт, мэдээлэл болж өгдөгөөрөө онцлог юм. Судалгаа нь олон нийт, хувийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хувьд соён гэгээрүүлэх, ойлголт мэдлэг түгээх чухал арга хэрэгсэл болдог. Судалгааг тогтмол хугацаанд давтан явуулснаар олон нийтийн ойлголт, хандлагад гарч буй өөрчлөлтийг тодорхойлох ач холбогдолтой болдог. Түүнчлэн энэхүү судалгаанаас гадна бизнес эрхлэгчдийн ойлголт, төсөөллийг тодорхойлох зорилгоор Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааг мөн явуулдаг. Төслийн хүрээнд мөн Боловсролын салбарын ил тод байдал, ёс зүй, авлигын асуудал судалгааг явуулсан бөгөөд эдгээр судалгаануудаас Монгол улс дахь авлигын нөхцөл байдлыг ерөнхий дүр зургийг харах боломжтой юм.

## СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

- ✔ Одоогийн Засгийн Газар энэ чиглэлд илүү сайн ажиллана гэдэгт оролцогчдын дөнгөж 11.0 хувь итгэлтэй байна. Авлигатай тэмцэхэд одоогийн Засгийн Газар, Ч.Сайханбилэгийн тэргүүлж байсан өмнөх Засгийн Газраас тааруухан ажиллана гэж судалгаанд оролцогчдын 21.3 хувь үзэж байна.
- ✔ Оролцогчдын 604 хувь сүүлийн гурван жилд авлига өссөн гэж үзэж байхад, 10.6 хувь нь эсрэгээрээ буурсан гэж хариулжээ.
- ✔ Өрхийн түвшний буюу жижиг хээл хахууль буурсан гэсэн статистик мэдээ гарсан байна. 2017 оны 3 сард өрхүүдийн 5.7 хувь сүүлийн гурван сарын хугацаанд ямар нэгэн байдлаар хахууль өгсөн гэж хариулжээ. Энэ нь өмнөх жилийнхээс нэг хувиар бага, өмнөх жилүүдийнхээс хамгийн бага үзүүлэлт юм.
- ✔ Судалгаанд оролцогчдын 81.8 хувь нь “Авлига өгч байгаа хүнд авлига авч байгаа хүнтэй адил хариуцлага хүлээлгэнэ” гэсэн тодорхойлолтыг дэмжиж байгаа нь авлига, хээл хахуулийг нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөхгүй хандлага өсөж байгааг илэрхийлж байгаа бөгөөд өмнөх жилүүдтэй харьцуулахад энэ нь хамгийн өндөр үзүүлэлт юм.
- ✔ Авлигатай холбоотой асуудлаар TV9 болон Фейсбүүк мэдээллийн гол эх сурвалж болж байна. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд Фейсбүүкийн хэрэглээ хурдацтай өсөж байгаа бөгөөд авлигатай тэмцэхэд мэдээллийн чухал эх сурвалж болох хандлагатай байна.
- ✔ Авлигад хамгийн их өртсөн таван байгууллагад улс төрийн намууд, Засгийн Газар, Улсын Их Хурал багтсан байна.
- ✔ “Улс төрийн удирдах дээд албан тушаалтнууд улс орны түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэлгүй” (43.6 хувь), “Асуудлыг хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл болсон” (44.1 хувь) зэрэг нь авлигын гол шалтгаан болж байна.

- ☛ “Хүчтэй арга хэмжээ авах, хатуу шийтгэл оногдуулах” нь авлигатай тэмцэх хамгийн үр дүнтэй арга гэж хариулсан хүмүүсийн тоо 2014 онд 20.8хувь, 2015 онд 21.4, 2016 онд 24.6, 2017 онд 28.5 хувь болж тус тус өссөн байгаагаас харахад авлигын эсрэг илүү хатуу тэмцэх ёстой гэсэн хандлагын өөрчлөлт гарч байна. Ил тод байдал, иргэний хяналт болон цалин, хөлсийг нэмэгдүүлэх зэрэг бусад аргуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж хариулсан хүмүүсийн тоо бүүржээ. 2016 онд оролцогчдын 10.5 хувь “Цалин хөлсийг нэмэгдүүлэх” гэж хариулсан бол 2017 онд 8.2 хувь ийм хариулт өгсөн байна. Түүнчлэн, “Засаг захиргааны шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, ил тод болгох” гэж хариулсан оролцогчдын тоо 12.9 хувиас 10.9 хувь болж, “Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллагуудын тавих хяналтыг хүчтэй болгох” нь авлигатай тэмцэх үр дүнтэй арга гэж үзсэн хүмүүсийн тоо 13 хувиас 11.4 хувь болж бүүржээ.
- ☛ Авлигатай тэмцэхэд иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудын манлайлал, оролцоог чухалчлах хандлага нэмэгдэж байна. 2013 оны 9 сарын байдлаар судалгаанд оролцогчдын 9.5 хувь иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудыг манлайлагч хэмээн үзэж байсан бол 2017 оны 3 сард энэ тоо 11.3 хувь болсон байна. Гэсэн хэдий ч энэ нь дээд түвшний авлигад хамаарахгүй юм. Олон нийтийн зүгээс дээд түвшний Авлигатай тэмцэхэд иргэний нийгэм, ТББ-уудын оролцоог чухалчлах хандлага үлэмж хэмжээгээр буурсан буюу 2013 оны 3 сард 12.8 хувь байсан бол 2017 оны 3 сард 6.3 хувь болсон.

# 1 МОНГОЛ УЛСАД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД



## 1. МОНГОЛ УЛСАД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД


Энэхүү судалгаанд оролцогчдоос “Монгол Улсад тулгамдаж буй томоохон асуудлуудын талаар юу гэж бодож байгаа” талаар нээлттэй асуулт хэлбэрээр асуусан. Судалгааны энэ хэсэгт нийт 90 ангилсан сонголтот хариултыг ашигласан. Зураг 1.1 болон 1.2-т Монгол Улсад тулгарч буй гол 10 асуудлыг илэрхийлэн харууллаа.

Энэхүү судалгаа болон Сант-Марал Сангийн (СМС) хийж гүйцэтгэсэн бусад судалгаанаас (Улс төрийн Барометр) харахад “Ажилгүйдэл” нь Монгол Улсын хамгийн тулгамдсан асуудал хэвээр байсаар байна. Ажилгүйдэл болон авлигын 2016 оны 3 сарын үеийн үзүүлэлтийг 2017 оны 3 сарынхтай харьцуулбал огцом өссөн байна. “Ажилгүйдэл” 27.8 хувиас 34.6 хувь, “Авлига” 7.7 хувиас 9.6 хувь болтлоо өсөж, тулгамдсан асуудлын дөрөвдүгээр байрнаас гуравруу шилжсэн байна.


“Ажилгүйдэл” тулгамдсан асуудал болсон гэдгийг 2013 оны 9 сараас тасралтгүй өссөн тоон үзүүлэлтээс (Зураг 1.2) харж болно. “Авлига”-ын үзүүлэлт мөн адил өссөн бөгөөд 9.9 хувь байгаа нь 2010 оны 9 сараас хойшхи (Зураг 1.3) хамгийн өндөр үзүүлэлт юм.

2017 оны 3 сард “Хүнд суртал”-ыг тулгамдсан 10 гол асуудлын нэг гэж үзсэн байна (2015, 2016 онд тулгамдсан 10 гол асуудалд “хүнд суртал” багтаагүй). “Хүнд сурталын” талаарх олон нийтийн ойлголт авлигатай салшгүй холбогдож байна.


**Зураг 1.1: 2017 оны 3 сар: Тулгамдаж буй гол асуудлууд**



**Зураг 1.2:** «Ажилгүйдэл»-ийг гол түлгамдаж буй асуудал гэж үзэх хандлага (2006 - 2017 он)




**Зураг 1.3:** «Авлига»-ыг гол түлгамдаж буй асуудал гэж үзэх хандлага (2006 - 2017 он)



Ажилгүйдэл болон авлигын асуудлыг хэрхэн үзэж байгааг оролцогчдын хүйсээр нь ялган авч үзэхэд ойролцоо гарсан ч, эмэгтэйчүүд ажилгүйдлыг тулгамдаж буй асуудал мөн гэж үзсэн байхад эрэгтэйчүүд үл ялиг илүүтэйгээр авлигыг тулгамдсан асуудал гэж үзсэн байна.

*Зураг 1.4: Ажилгүйдэл болон авлигыг тулгамдаж буй асуудал гэж үзсэн хандлага (2006 - 2017 он), Хүйсээр*






# 2 АВЛИГЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА




## 2. АВЛИГЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА

Авлигын үр нөлөөг үнэлэх явцад хувийн амьдрал, бизнесийн орчинд нөлөөлөх байдлын талаарх олон нийтийн хандлага (Зураг 2.1) хэвээр байгаа нь ажиглагдсан. Авлигын үр нөлөөний дундаж утга (1“огт” авлигын үр нөлөө байхгүй, 4“их хэмжээгээр” авлигын үр нөлөөнд өртсөн) нь маш бага хэлбэлзэлтэй байна. Хэдийгээр хувийн амьдралд үзүүлэх авлигын үр нөлөөг “маш бага” гэж үзсэн ч, бизнесийн орчинд “тодорхой хэмжээгээр” нөлөөлдөг гэсэн үр дүн гарчээ. Бидний ажигласнаар 2014 оны 3 сараас хойш авлигын үр нөлөө зөвхөн улс төрд тогтмол өссөн хандлагатай байна. Түүнчлэн 2016 оны судалгаанаас харахад бизнесийн орчинд авлигын үр нөлөө өөрчлөгдөх хандлагатай байна. Сүүлийн хоёр жилийн судалгааны үр дүнг харьцуулан харвал хувь хүний амьдралд үзүүлэх авлигын үр нөлөөний үнэлгээний утгад өөрчлөлт бараг ороогүй байхад бизнесийн орчинд үзүүлэх үр нөлөөний дундаж утга 0.08, улс төрд 0.1-ээр тус тус өссөн байна (Зураг 2.2).

**Зураг 2.1:** Хувь хүний амьдрал, бизнесийн орчин, улс төрд авлигын үзүүлэх үр нөлөө




**Зураг 2.2:** Авлигын үр нөлөө - 2016, 2017 онд




Жил бүрийн судалгааны үр дүнгээс харахад маш бага өөрчлөлтүүд гарсаар байна. “Манай оронд авлига, хээл хахууль асуудлыг шийдвэрлэх түгээмэл арга зам болсон” гэсэн оролцогчдын хандлага 2006 оноос хойш бараг өөрчлөгдөөгүй буюу 2006 оны 3 сард оролцогчдын 91.2 хувь, 2017 оны 3 сард 86.7 хувь энэ тодорхойлолттой санал нийлжээ. (Зураг 2.3). Харин 2006 оны 3 сараас 2014 оны 3 сар хүртэл хугацаанд дээрх байр суурийг хүлээн зөвшөөрсөн оролцогчдын тоо зэрэг хандлагатай болж, 81.3 хувь болтлоо буурсан ч 2014 оны 3 сараас өнөөг хүртэл энэ хандлага өссөн байна.

**Зураг 2.3:** Манай улсад авлига нийтлэг зүйл болсон




Судалгаанд оролцогчид авлигыг хүлээн зөвшөөрөх хандлага ажиглагдсаар байна (Зураг 24). Авлигыг тодорхой хэмжээнд байж болно гэдгийг хүлээн зөвшөөрсөн оролцогчдын тоо үргэлж өндөр байсаар ирсэн ч хамгийн сүүлд хийгдсэн судалгаанаас харахад энэ тоо улам өсч 2016 оны 3 сард 60.7 хувь байсан бол 2017 оны 3 сард 69 хувь болжээ.

**Зураг 2.4: Авлига тодорхой хэмжээнд байхыг хүлээн зөвшөөрнө**




Сүүлийн жилүүдэд Монголын улс төрийн бүтэц, тогтолцоо шүүмжлэлийг дагуулж байгаа тул авлигыг бууруулах улс төрийн тогтолцооны чадавхид итгэх үзүүлэлт бүүрсан. (Зураг 2.5). 2014 оны 3 сард судалгаанд оролцогчдын тал хувь нь улс төрийн систем авлигыг таслан зогсооход ахиц, амжилт гаргасан гэдэгт итгэлтэй байсан бол (51.6 хувь) 2015 оны 3 сард дөнгөж гуравны нэг орчим оролцогчид (38.5 хувь) үүнтэй санал нийлсэн байна. Хэдийгээр энэ тоо 2016 оны 3 сард бага зэрэг өссөн (41.9 хувь) ч 2017 онд оролцогчдын гуравны нэг (34.6 хувь) “улс төрийн систем авлигатай тэмцэж чадна” гэдэгт итгэж байна хэмээн хариулсан. Түүнчлэн “улс төрийн тогтолцоо авлигатай тэмцэж чадна” гэдэгт огт итгэхгүй байгаа оролцогчдын тоо өсч 2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь буюу 59.5 хувь итгэхгүй байгаагаар илэрхийлжээ.

**Зураг 2.5: Өнөөгийн улс төрийн тогтолцоо авлигатай тэмцэхэд амжилт гаргаж байна**




Тоймлон авч үзвэл төрийн байгууллагуудаас илүүтэйгээр иргэний нийгмийг авлигаас урьдчилан сэргийлэх чадамжтай гэж үнэлсэн байна (Зураг 2.6 – Зураг 2.7). 2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь “Иргэний нийгмийн байгууллагууд авлигаас урьдчилан сэргийлж чадна” гэдэгт итгэлтэй байна гэсэн бол талаас арай бага хувь нь “Зөвхөн төрийн байгууллагууд авлигаас урьдчилан сэргийлж чадна” гэж хариулсан байна (48.4 хувь).


**Зураг 2.6: Иргэний нийгэм авлигаас урьдчилан сэргийлж чадна**






**Зураг 2.7:** Авлигаас урьдчилан сэргийлэхэд зөвхөн төрийн байгууллагууд тусалж чадна



Иргэд, ТББ, улс төрчдийн талаарх хандлага мөндээрхтэй адил өөрчлөлттэй байна. (Зураг 2.8–Зураг 2.9). 2017 оны 3 сард оролцогчдын 77% хувь нь “Авлигатай тэмцэх ажлыг иргэд, ТББ-ууд удирдан зохион байгуулж байна” гэж хариулсан бол 86.3 хувь нь “Улс төрчид авлигаас ашиг олж болох учраас авлигатай тэмцэх чин эрмэлзэлгүй байдаг” гэж бодож явдгаа илэрхийлсэн байна.

**Зураг 2.8:** Өнөөгийн нөхцөлд иргэний хөдөлгөөн, төрийн бус байгууллагууд авлигын эсрэг тэмцэх гол хүчин юм

**Зураг 2.9: Улс төрчид авлигаас ашиг олж болох учраас авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл байхгүй**



2009 оны 9 сарын судалгааны үрдүнг (Зураг 2.10) эс тооцвол 2006 оноос хойшхи судалгаа бүрт оролцогчид “Хүнд суртлыг шийдвэрлэх цорын ганц гарц бол хахууль өгөх” гэдэг байр суурьтай санал нийлж байжээ. 2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь (57.6 хувь) хүнд суртлыг шийдвэрлэхийн тулд хахууль өгнө гэж хариулж байна.


**Зураг 2.10:** Нийгэмд газар авсан хүнд суртлыг шийдэх ганц арга бол хээл хахууль өгөх**Зураг 2.11:** Хээл хахууль нь зарим үед шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг



Харьцуулж үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь “Томоохон бизнес эрхлэгчидтэй харьцуулахад авлига жижиг, дунд бизнес эрхлэгчдэд илүү сөргөөр нөлөөлж байна” гэдэгтэй санал нийлжээ. Энэ хандлага жил бүр харилцан адилгүй байсаар ирсэн бөгөөд хамгийн бага хувь буюу 60.9 хувь 2009 оны 3 сард ажиглагдсан. Харин 2017 оны 3 сард судалгаанд оролцогчид энэ тодорхойлолтыг хамгийн их буюу 87 хувиар хүлээн зөвшөөрчээ.


Түүнчлэн “томоохон бизнесүүд авлигын эх үүсвэрүүдийн нэг” гэдэгтэй санал нийлж байгаа оролцогчдын тоо энэ удаа 78 хувьтай гарсан байна (Зураг 2.13). Хэдийгээр өмнөх жилүүдэд энэ тоо тогтмол хэлбэлздэг байсан ч нийт оролцогчдын дунджаар дөрөвний гурав нь үүнтэй санал нийлдэг.

**Зураг 2.12: Авлигаас болж том бизнесийнхэнээс илүүтэйгээр жижиг, дунд бизнес эрхлэгчид хохирдог**



**Зураг 2.13:** Том бизнес эрхлэгчид авлигын гол эх үүсвэр болдог гэдэгтэй та санал нийлж байна үү?


Сүүлийн арван жилийн хугацаанд гарсан эерэг өөрчлөлтүүдийн нэг нь орон нутгийн засаг захиргааны нэр хүнд иргэдийн дунд өссөн явдал юм (Зураг 2.14). Судалгааны үр дүнгээс харахад “Орон нутгийн засаг захиргааны ажилтнууд ерөнхийдөө итгэл хүлээхүйц, хариуцлагатай хүмүүс байдаг” гэсэн байр суурьтай иргэдийн тоо тогтмол өсөж байна. Өмнөх жилүүдтэй харьцуулбал 2006 оны 3 сард судалгаанд оролцогчдын гуравны нэг нь (38.1 хувь) ийнхүү үзэж байсан бол 2017 оны 3 сард талаас илүү хувь нь (54.0 хувь) санал нийлжээ.

**Зураг 2.14:** Орон нутгийн захиргааны албан хаагчид ихэнхдээ итгэл үзүүлж болохуйц, хариуцлагатай хүмүүс байдаг


Оролцогчдын дийлэнх хувь нь “Иргэд авлигыг бууруулахад үүрэг хүлээх ёстой” гэсэн байр суурийг дэмжиж байгаа бөгөөд энэ нь авлигатай тэмцэхэд иргэний нийгмийн оролцоо нэмэгдэж байгаагийн илрэл юм. (Зураг 2.15). 2012 оны 11 сараас 2017 оны 3 сар хүртлэх хугацаанд ийнхүү үзэж буй иргэдийн хувь 89.1-ээс 92.9 хувь болж өсчээ. Харин “хэлэх санал байхгүй” эсвэл хариулаагүй оролцогчдын тоо 2012 оны 11 сард 4.6 хувь байсан бол 2017 оны 3 сард 1.0 хувь болж буурсан байна. Энэ нь авлигын эсрэг тэмцэх олон нийтийн мэдлэг ойлголтод эерэг өөрчлөлт гарсныг харуулж байна.

Оролцогчид “Авлигаас болж шийдвэр гаргагчдаас илүүтэйгээр жирийн иргэд хохирдог” (Зураг 2.16) гэсэн байр суурийг хэрхэн үзэж байгааг харвал дээрхтэй мөн ижил хандлага ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл 2012 оны 11 сард судалгаанд оролцогчдын 72 хувь уг байр суурьт “хэлэх санал байхгүй” гэж хариулж байсан бол 2017 оны 3 сард энэ тоо 1.8 хувь болж буурсан байна. Харин энэ хандлагыг дэмжиж буй иргэдийн хувь 2012 оны 11 сард 85.1 байсан бол 2017 оны 3 сард 91.9 хувь болж өссөн байна.

**Зураг 2.15:** Авлигыг бууруулахад иргэд өөрсдөө хувь нэмэр оруулах ёстой




**Зураг 2.16:** Шийдвэр гаргагчид өөрсдөө авлигаас төдийлөн хохирдоггүй, жирийн иргэд л авлигаас болж хохирч байна



Авлигатай тэмцэх хууль, эрх зүйн орчны талаарх хандлага сөрөг ажиглагдаж байна (Зураг 2.17).


Авлигын эсрэг үйлчилж буй хууль, эрх зүйн зохицуулалтын талаархи судалгаанд оролцогчдын хандлагыг хоёр хэсэгт хувааж болно. 2006 оны 3 сараас 2008 оны 9 сар хүртэлх хугацаанд оролцогчдын маш бага хувь “эрх зүйн зохицуулалт үр дүн муутай байсан” гэж хариулсан нь сайшаалтай байсан хэдий ч 2009 оны 3 сараас өөрчлөгдсөн. 2009 оны 9 сард судалгаанд оролцогчдын 70.3 хувь нь авлигатай тэмцэх эрх зүйн зохицуулалтыг үр дүнгүй гэж хариулсан бол 2017 оны 3 сард энэ тоо 87.7 хувь хүртэл өссөн байна. Түүнчлэн 2009 оны 9 сараас энэ талаар “санал байхгүй” гэж хариулсан оролцогчдын тоо буурсан. “Хариулаагүй” эсвэл “Мэдэхгүй” гэсэн хариултууд 2009 оны 9 сард 13.8 хувь байсан бол 2017 оны 3 сард 2.6 хувь болж буурчээ.

**Зураг 2.17:** Авлигын эсрэг хууль тогтоомж үр дүнгүй байна




Жил бүрийн судалгаанаас үзэхэд “төрийн албан хаагчдын хээл хахуулийн гол шалтгаан нь бага цалин” гэж үзсэн оролцогчдын тоо байнга өөрчлөгдөж байна (Зураг 2.18). Харин “санал байхгүй” гэж хариулсан оролцогчдын тоо харьцангуй өндөр буюу нийт оролцогчдын 10 орчим хувь байсан (2017 оны 3 сард 8.3 хувь). Энэ байр суурийг нийт оролцогчдын талаас илүү хувь нь (59.1 хувь) дэмжиж байсан бол 32.6 хувь нь огт санал нийлээгүй. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэйгээр цалин бага байх нь авлигад нөлөөлдөг гэж хариулжээ. (Зураг 2.19)


**Зураг 2.18:** Төрийн албан хаагчид бага цалин авч байгаа нь авлигын гол шалтгаан болдог






**Зураг 2.19:** Төрийн албан хаагчид бага цалин авч байгаа нь хээл хахуулийн гол шалтгаан болдог (Хүйсээр)

“Авлига авсан төрийн албан хаагчдад хатуу шийтгэл оногдуулах хэрэгтэй” гэсэн байр суурийг дэмжигчдийн тоо өнгөрсөн хугацаанд өссөн байна (Зураг 2.20). 2012 оны 11 сард судалгаанд оролцогчдын 76.7 хувь энэ байр суурийг дэмжиж байсан бол 2017 оны 3 сард энэ тоо 82.9 хувь болж өсжээ.

**Зураг 2.20:** Албан тушаалтнуудад хатуу ял шийтгэл оногдуулах нь авлигыг зогсооно


Түүнчлэн, “Авлига өгч байгаа хүн авлига авч байгаа хүнтэй адил хариуцлага хүлээх ёстой” гэсэн байр суурийг дэмжигчдийн тоо өмнөх жилүүдтэй харьцуулахад хамгийн өндөр буюу 81.8 хувь болжээ (Зураг 2.21). 2007 онд энэ тоо хамгийн бага буюу 66 хувьтай байсан аж.

**Зураг 2.21:** Хээл хахууль өгсөн хүн түүнийг авсан хүнтэй адил гэм буруутай



“Авлигатай тэмцэх хууль улс төрийн ямар нэг нөлөөгүй хэрэгжиж байна” гэдэг дээр судалгаанд оролцогчдын санал хуваагдсан байна (Зураг 2.22). 2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын тавны нэг буюу 20.1 хувь нь “хэлэх саналгүй” гэж хариулсан байхад 40 орчим хувь нь (39.5 хувь) авлигатай тэмцэх хуулийн хэрэгжилтэд улс төрийн нөлөөлөл орсон гэж үзсэн байна. Харин 40 орчим хувь нь (40.4 хувь) улс төрийн ямар нэгэн нөлөөнд автаагүй гэж хариулжээ.

**Зураг 2.22:** Авлигатай тэмцэх бодлогын хэрэгжилт улс төрийн сонирхол агуулаагүй








# 3 АВЛИГЫН ЧИГ ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ




### 3. АВЛИГЫН ЧИГ ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ

Жил бүрийн судалгааны үр дүнгээс харахад “авлигын түвшин буурсан” гэж үзэж байсан оролцогчдын тоо өнгөрсөн гурван жилийн туршид өөрчлөгджээ. (Зураг 3.1). Авлигын түвшин “Ихээхэн өссөн” гэж хариулсан оролцогчдын тоо 2006 оны 3 сараас 2014 оны 3 сар хүртэл хугацаанд тогтмол буурч байсан ч 2014 оны 3 сараас энэ үзүүлэлт эсрэгээрээ өөрчлөгдөж, авлигын түвшин өсөж байна гэж хариулсан оролцогчдын тоо сүүлийн гурван жилтэй харьцуулахад өсөх хандлагатай болжээ. 2014 оны 3 сард судалгаанд оролцогчдын 17% хувь сүүлийн гурван жилд авлига нэмэгдсэн гэж хариулж байсан бол 2017 оны 3 сард энэ тоо 2 дахин нэмэгдэж 34.2 хувь болжээ. Харин 2014 оны 3 сард, нийт оролцогчдын 25 хувь нь сүүлийн гурван жилийн хугацаанд авлигын түвшин “Бага зэрэг буурсан” гэж хариулж байсан бол 2017 оны 3 сард энэ тоо 10 хувиар буурсан байна. Авлигын чиг хандлагыг хөдөлмөр эрхлэлтийн салбараар нь авч үзвэл ТББ болон хувийн хэвшлийнхэнтэй харьцуулахад төрийн байгууллагын албан хаагчдад илүү сөрөг үнэлгээ өгсөн байна (Зураг 3.2-Зураг 3.3).


**Зураг 3.1: Өнгөрсөн гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?**



**Зураг 3.2:** Өнгөрсөн гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? (Төрийн байгууллагын ажилтнууд)




**Зураг 3.3:** Өнгөрсөн гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ? (ТББ болон хувийн хэвшилд ажиллагсдын хариулт)




Өнгөрсөн хугацаанд авлигын түвшний цаашдын хандлагын талаарх хүмүүсийн санал бодол ялгаатай байсан. 2013 оны 9 сард судалгаанд оролцогчдын ихэнх нь “авлигын түвшин буурна” гэж хариулж байсан нь хамгийн эерэг хандлага байв. (Зураг 3.4). Тухайн үед оролцогчдын талаас илүү хувь нь ирэх 3 жилд авлигын түвшин буурна гэдэгт итгэлтэй байв. (52.5 хувь). Харин 2017 оны 3 сард энэ эерэг хандлага 31.9 хувь хүртэл буурсан байна.

Өнгөрсөн жилүүдийн судалгаанаас харахад хувийн хэвшлийнхэн болон ТББ-ын ажилтнуудтай харьцуулахад төрийн байгууллагын албан хаагчид “авлигын түвшин цаашид буурна” гэдэгт итгэлгүй, сөрөг хандлагатай байсан байна (Зураг 3.5–Зураг 3.6).


**Зураг 3.4:** Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ?



**Зураг 3.5:** «Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ?» (Төрийн байгууллагийн ажилтнууд)



**Зураг 3.6:** «Ирэх гурван жилд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдөх вэ?» (Хувийн болон ТББ-үүд)





# 4 ӨРХИЙН ТҮВШНИЙ АВЛИГА БОЛОН ХЭЭЛ ХАХУУЛЬ






## 4. ӨРХИЙН ТҮВШНИЙ АВЛИГА БОЛОН ХЭЭЛ ХАХУУЛЬ

Жилээс жилд судалгаанд оролцогчид өрхийн түвшний авлига бүүрч байгаа гэж хариулж байна (Зураг 4.1). Өрхийн түвшний авлига ийнхүү буурахад хээл хахууль нэхэхэд хүмүүс илүү их дургүйцдэг болсон, хувь хүн авлигад өртөх нь багассан, авлигын эсрэг санал санаачлага амжилттай хэрэгжсэн зэрэг хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн юм.

Өөрөө эсвэл өрхийн аль нэг гишүүн нь сүүлийн 3 сарын хугацаанд ямар нэгэн байдлаар авлига өгсөн гэж 2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын 5.7 хувь нь хариулсан байна. Үүн дээр тодруулаад хэлэхэд өрхийн түвшний авлига 2006 оноос хойш буурсныг өмнөх судалгааны үр дүнгээс тодорхой харж болох хэдий ч хээл хахуулийн хэлбэр төвөгтэй бас нарийн болсон. Иймд манай судалгаанд ашиглагдсан хэмжүүрүүд өрхийн түвшний авлига, хээл хахуулийн хэлбэр бүрийг хамруулаагүй байх магадлалтай.


Жишээлбэл, “хандив”-ыг юу гэж ойлгож байгаа талаарх олон нийтийн санал хуваагдсан байна (Зураг 4.2). “Хандив” нь цэцэрлэгээс эхлээд Улс төрийн нам хүртэл Монголын нийгмийн бүхий л түвшинд оршин тогтнож байна. Хандивын үйл ажиллагааны зарим нь авлигын мөн чанарыг маргаангүй агуулж байгаа ч, үүнийг байгууллагын үйл ажиллагааг “дэмжих” нэрийн дор халхавчилж ирсэн. 2017 оны судалгааны үр дүнгээс харахад “Хандив”-ыг хээл хахуулийн нэг хэлбэр гэж үзэхгүй байгаа иргэдийн тоо бага зэрэг өсжээ.

**Зураг 4.1:** Сүүлийн 3 сарын хугацаанд Та болон танай гэр бүлийн гишүүд ямар нэгэн хэлбэрээр хээл хахууль өгсөн үү? («Тийм» гэсэн хариулт)






**Зураг 4.2:** Хандив нь хээл хахууль үү эсвэл байгууллагын үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх нэг хэлбэр үү?




2007-2008 оны дэлхийн санхүүгийн хямрал Монголын эдийн засагт нөлөөлж, зарим өрхүүдэд маш хүнд туссан гэдэг нь судалгааны явцад анзаарагдсан. 2009 оны 3 сард судалгаанд оролцогчдын ихэнх нь (42.5 хувь) сүүлийн гурван сарын хугацаанд өгсөн авлига тухайн гэр бүлийн төсөвт “Маш хүнд” туссан гэж хариулсан байна (Зураг 4.3). 2017 онд Монгол улс эдийн засгийн хямралд өртсөн ч, Засгийн Газраас нийгмийн халамжид их хэмжээний мөнгө зарцуулж амьжиргааны түвшинг тодорхой хэмжээнд тогтворжуулсан. (Зураг 4а). Иймд 2017 оны 3 сард хийгдсэн судалгаагаар авлига өгсөн хүмүүсийн дөнгөж 20.5 хувь “авлига өгсөн явдал өрхийн төсөвт маш хүнд туссан” гэж хариулсан нь халамжийн бодлогтой холбоотой байх магадлалтай.

**Зураг 4.3:** Авлига нь танай өрхийн төсөвт хэрхэн нөлөөлж байна вэ?




**Зураг 4.4: Амьдралын чанарын үнэлгээ**

(Эх сурвалж: СМС Улс төрийн Барометрийн мэдээлэл)




2017 оны 3 сард “Эрх мэдэлтнүүдтэй холбогдож хүндрэлд орохгүйн тулд хахууль өгсөн” гэж хариулсан оролцогчдын тоо огцом өссөн байна (Зураг 4.5). 2016 оны 3 сард энэ үзүүлэлт 11 хувьтай байсан бол 2017 оны 3 сард 21.8 хувь болтлоо өсжээ. Ингэж хариулсан оролцогчдыг хүйсээр нь авч үзвэл томоохон ялгаа харагдаж байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн 15.8 хувь, эрэгтэйчүүдийн 27.5 хувь “хахууль өгч асуудлыг шийдвэрлэхийг илүүд үзнэ” гэж хариулсан байна (Зураг 4.6). Жил жилийн судалгаанаас харахад авлига өгөх явдал судалгаанд оролцогчдын дунд буурсан байна (2017 оны 3 сард оролцогчдын 5.7 хувь). Түүнчлэн, оролцогчдын авлига өгөх хэлбэр өөрчлөгдөж байгаа бөгөөд үүнд улирлын чанартай хүчин зүйлс нөлөөлдөг байж болох тул үүнийг чанарын судалгаагаар тодорхойлж болно.

**Зураг 4.5:** Дараах хүчин зүйлсийн аль нь сүүлийн гурван сард хахууль өгөх шалтгаан болсон бэ?



**Зураг 4.6:** Дараах хүчин зүйлсийн аль нь сүүлийн гурван сард хахууль өгөх шалтгаан болсон бэ? (Хүйсээр дэлгэрэнгүй задалсан)



Өнгөрсөн жилийн судалгаатай харьцуулбал өрхийн түвшний авлигын статистик мэдээ энэ жил өөрчлөгдөөгүй байна. (Зураг 4.7 болон Хүснэгт 4.1). Өрхийн түвшний авлигын дундаж хэмжээ 2016 онд 336,000 төгрөг байсан бол 2017 онд 370.000 төгрөг болж, бага зэрэг өсжээ. 2016 онд оролцогчдын 6.7 хувь хахууль өгсөн гэж хариулсан бол 2017 онд энэ тоо 5.7 хувь болж буурсан хэдий ч 2017 онд хахууль өгөхөд зарцуулсан нийт мөнгөн дүн 18.1 тэрбум төгрөг байгаагаас харахад нийт дүн өмнөх жилийнхтэй бараг ижил байна. Хэдийгээр 2008-2009 онд хээл хахууль өгөхөд зарцуулсан нийт мөнгөн дүн хамгийн өндөр, мөн 2013, 2014 онд өгсөн хээл хахуулийн дундаж мөнгөн дүн хамгийн өндөр гарсан ч хахууль өгөх өрхийн тоо сүүлийн 10 жилд бага багаар буурсан үзүүлэлттэй байна.

**Зураг 4.7: Өрхийн түвшний хээл хахуулийн талаарх статистик мэдээ****Хүснэгт 4-1: Өрхийн түвшний хээл хахуулийн талаарх статистик мэдээ**

Хээл хахуулийн дундаж дүн (1000Т-р)	181	136	102	187	180
Хээл хахууль өгсөн өрхийн эзлэх хувь	26%	28%	23%	22%	19%
Өгсөн хээл хахуулийн нийт дүн (Тэрбум Т-р)	28.8	23.3	14.8	26	23.2
Өрхийн тоо	611000	611000	632500	632500	645700
Статистикийн жил бүрийн эмхтгэл	2005	2005	2006	2006	2007
	9 сар 2008	3 сар 2009	9 сар 2009	3 сар 2010	9 сар 2010
Дундаж хээл хахууль (1000Т-р)	298	397	308	195	416
Хахууль өгсөн өрхийн хувийн жин	21%	15%	20%	16%	13%
Хахууль өгсөн нийт дүн (Тэрбум Т-р)	424	40.3	41.7	21.2	38.8
Өрхийн тоо	645700	677800	677800	677800	717000
Статистикийн эмхтгэл	2007	2008	2008	2008	2009
	4 с ар 2011	11 сар 2012	3 сар 2013	9 сар 2013	3 сар 2014
Дундаж хээл хахууль (1000Т-р)	319	391	502	525	520
Хахууль өгсөн өрхийн хувийн жин	8.80%	12.40%	8.75%	7.64%	7.57%
Хахууль өгсөн нийт дүн (Тэрбум Т-р)	20.8	35.9	32.6	30.8	30.2
Өрхийн тоо	742000	742000	742000	768300	768300
Статистикийн эмхтгэл	2010	2010	2010	2012	2012
	4 с ар 2015	3 с ар 2016	3 с ар 2017		
Дундаж хээл хахууль (1000Т-р)	277	336	370		
Хахууль өгсөн өрхийн хувийн жин	6.77%	6.70%	5.70%		
Хахууль өгсөн нийт дүн (Тэрбум Т-р)	14.9	18.5	18.1		
Өрхийн тоо	794090	823412	859100		
Статистикийн эмхтгэл	2013	2014	2015		



# 5 ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГА






## 5. ДЭЭД ТҮВШНИЙ АВЛИГА

2012 оны судалгаанд бид анх удаа дээд түвшний авлигын талаарх ойлголтыг танилцуулж байсан. Үүнээс 6 жилийн дараа олон нийтийн дунд дээд түвшний авлигын талаарх ойлголт нэмэгдсэн гэдэг нь харагдаж байна (Зураг 5.1). Энэ удаагийн судалгаанд оролцогчдын ойролцоогоор дөрөвний нэг нь төрийн байгууллагын албан хаагчдыг дээд түвшний авлигатай холбосон байна. Мөн дээд түвшний авлига нь улс төрийн ашиг сонирхолтой холбоотой байдаг гэж үзэх хүмүүсийн тоо өссөн гэж үзэж болохоор байна. 2012 онд “мэдэхгүй” гэсэн хариулт 20.8 хувь байсан бол 2017 онд 7.9 хувь болтлоо буурсан үзүүлэлтээс харахад өнгөрсөн 6 жилийн хугацаанд дээд түвшний авлигын талаарх хүмүүсийн ойлголт, мэдлэг нэмэгдсэн байна.


Мөн дээд түвшний авлига улс оронд ихээхэн хэмжээний хор хохирол учруулдаг гэж үзэж буй оролцогчдын тоо 2014 оны 3 сараас хойш өсөж байна. Дээд түвшний авлига улс төрийн ашиг сонирхолтой салшгүй холбоотой байдаг гэж хариулсан оролцогчдын тоо мөн өссөн үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч “дээд түвшний авлигын эх үүсвэр бол үндэсний болон гадаадын томоохон бизнес эрхлэгчид” гэж бодож буй иргэдийн тоо буурчээ.

**Зураг 5.1: Та дээд түвшний авлигын талаар ямар ойлголттой вэ?**




2012 оны 11 сард судалгаанд оролцогч таван хүн тутмын нэг нь Монгол Улсын дээд түвшний авлигын түвшинг тодорхойлж хэлж чадахгүй, энэ талаар ойлголтгүй байсан. Харин өнгөрсөн 6 жилийн хугацаанд дээд түвшний авлигын талаарх иргэдийн ойлголт, мэдлэг нэмэгдсэн тул энэ удаа Монгол Улсын дээд түвшний авлигын түвшинг тодорхойлж чадаагүй иргэдийн тоо 6.5 хувь байна. Дээд түвшний авлигын талаар саналаа илэрхийлсэн хүмүүсийн ихэнх нь “манай улсад энэ төрлийн авлигын түвшин маш өндөр байна” гэж хариулжээ. 2012 оны 11 сард судалгаанд оролцогчдын 43.1 хувь ингэж хариулсан бол 2017 оны 3 сард 54.9 хувь болтлоо өсжээ.

**Зураг 5.2: Монголд дээд түвшний авлига ямар хэмжээнд байгаа вэ?**




2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын ихэнх нь дээд түвшний авлигын гол шалтгаан нь бизнес, улс төрийн сонирхолтой холбоотой гэж хариулсан байна (Зураг 5.3). 2012 оны 11 сард судалгаанд оролцогчдын 17.2 хувь нь дээд түвшний авлига нь гадаадын томоохон компаниудтай холбоотой гэж үзэж байсан бол 2017 оны 3 сард энэ тоо 12.4 хувь болж буурснаас үзвэл гадаад иргэдэд дургүй байх, гадуурхах үзэл харьцангуй багассан байна. Түүнчлэн эрх зүйн зохицуулалт боловсронгуй биш, хууль эрх зүйн орчин бүрэн төлөвшөөгүй байгаа нь дээд түвшний авлигын гол шалтгаан болж байна гэж иргэд үзсэн байна.

**Зураг 5.3: Таны бодлоор дээд түвшний авлига яагаад оршиж байна вэ? (Олон сонголттой хариулт)**


Дээд түвшний авлигын талаарх ойлголт, мэдлэг нэмэгдэхийн хэрээр өрхөд нөлөөлөх түүний хор уршгийн талаарх ойлголт нэмэгдэж байна. 2012 оны 11 сард судалгаанд оролцогчдын 42.4 хувь нь нөлөөллийг үнэлж чадахгүй байсан бол 2017 оны 3 сард нөлөөллийг үнэлж чадаагүй иргэдийн тоо дөнгөж 17.1 хувьтэй гаржээ. Түүнчлэн энэ жилийн судалгаанд оролцогчдын 12.9 хувь дээд түвшний авлигын өрхөд үзүүлэх нөлөөллийг “Маш их” хор уршигтай гэж үзсэн байна.

Амьжиргаан түвшин буурч үнийн өсөлт нэмэгдэхэд нөлөөлсөн гол шалтгаан бол дээд түвшний авлига гэж ихэнхи хүмүүс үзсэн байна (Зураг 5.5 – Зураг 5.6).

**Зураг 5.4:** Дээд түвшний авлига танд болон танай гэр бүлд ямар нэгэн байдлаар сөрөг нөлөө үзүүлдэг гэж та бодож байна уу?




**Зураг 5.5:** Хэрэв тийм бол танд эсвэл танай гэр бүлд ямар байдлаар нөлөөлж байна вэ? 2013 оны 3 сар






**Зураг 5.6:** Хэрэв тийм бол танд эсвэл танай гэр бүлд ямар байдлаар нөлөөлж байна вэ? 2017 оны 3 сар




Дээд түвшний авлигын төрлүүдээс “Албан тушаал” горилох, “Бэлэн мөнгөний” хээл хахуулийн хэлбэрийг хамгийн түгээмэл байна гэж үзсэн байна (Зураг 5.7 – Зураг 5.8). Монгол Улсын хуульд авлига өгсөн болон авсан хүнийг ялгалгүй гэм буруутайд тооцдог. “Бэлэн мөнгө” өгч байгаа тал үүнийхээ хариуд “Албан тушаал”д томилогдож, хамгийн их мөнгө өгсөн хүнд “Албан тушаал” олддог үзэгдэл бас ойлголт хэвийн болжээ.

**Зураг 5.7:** Та дээд түвшний авлигын талаар сонсож байсан бол, энэ нь ямар төрлийн авлига байсан бэ? (Олон сонголттой хариулт) 2013 оны 3 сар




**Зураг 5.8:** Та дээд түвшний авлигын талаар сонсож байсан бол, энэ нь ямар төрлийн авлига байсан бэ? (Олон сонголттой хариулт) 2017 оны 3 сар



2017 оны 3 сарын судалгаанд оролцогчид “дээд түвшний авлигатай тэмцэх гол байгууллага бол Авлигатай Тэмцэх Газар” гэж үзжээ. Нийт оролцогчдын гуравны нэг нь Авлигатай Тэмцэх Газар авлигын эсрэг үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах ёстой гэж хариулсан байна. Харин нөгөө талаас нь харвал, Засгийн Газар дээд түвшний авлигатай тэмцэх үйл ажиллагааг удирдах ёстой гэсэн байр суурьтай иргэдийн тоо 2017 оны 3 сард 6 хувиар өсөж 27.5 хувьд хүржээ. Харин 2013 оны 3 сард нийт оролцогчдын 12.8 хувь иргэний нийгмийн оролцоог дэмжиж байсан бол 2017 оны 3 сард энэ тоо 6.3 хувь болж буурсан байна.

**Зураг 5.9:** Таны бодлоор дээд түвшний авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? 2013 оны 3 сар



**Зураг 5.10:** Таны бодлоор дээд түвшний авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? 2017 оны 3 сар





# 6 АВЛИГАД ХАМГИЙН ИХ АВТСАН БАЙГУУЛЛАГУУД



## 6. АВЛИГАД ХАМГИЙН ИХ АВТСАН БАЙГУУЛЛАГУУД

Оролцогчдын зүгээс авлигын түвшинг хэрхэн үнэлсэн талаарх үр дүнг харвал, таван байгууллагыг авлигад хамгийн их автсан гэж 2015 оны 4 сараас хойш үзсээр байна (Хүснэгт 6.1). 2017 оны 3 сард Газрын албыг авлигад хамгийн их автсан байгууллага гэж үзсэн бол хоёрдугаарт нь Улс төрийн намууд орсон байна. “Газрын алба” болон “Улс төрийн намуудын” дундаж утга дөрөв рүү дөхөж очсон байгаагаас харахад энэхүү хэмжигдэхүүний хүрээнд эдгээр байгууллагууд авлигад “Нилээд их” хэмжээгээр автсан гэж хэлж болохоор байна (Зураг 6.1). 2006 оны судалгаатай харьцуулахад Газрын албаны үзүүлэлт 4.5-аас 4 болж буурсан байхад Улс төрийн намуудын хувьд 2007 онд 3.58 хувьтай байснаас 2017 онд 3.94 болж өсжээ.


**Хүснэгт 6-1: Авлигад хамгийн их автсан байгууллага, салбар**

	1 сэрэгтэй	2 сэрэгтэй	3 сэрэгтэй	4 сэрэгтэй	5 сэрэгтэй
3 сар-2017	Газар шилжэлт	Улс төрийн намууд	Үүс үүрхэй	УИХ/Хууль татвар байгууллага	Засгийн газар
3 сар-2016	Улс төрийн намууд	Газар шилжэлт	Үүс үүрхэй	УИХ/Хууль татвар байгууллага	Засгийн газар
4 сар-2015	Газар шилжэлт	Улс төрийн намууд	Үүс үүрхэй	Засгийн газар	УИХ/Хууль татвар байгууллага
3 сар-2014	Газар шилжэлт	Үүс үүрхэй торай үзвэрлэлт	Орон нутгийн захирал байгуулсан туслахууд	Шүүх	Газар
9 сар-2013	Газар шилжэлт	Үүс үүрхэй торай үзвэрлэлт	Орон нутгийн захирал байгуулсан туслахууд	Улс төрийн намууд	Үүс үүрхэй салбар дэлгэрүүлэх хөдөлгөөн
3 сар-2013	Газар шилжэлт	Үүс үүрхэй торай үзвэрлэлт	Орон нутгийн захирал байгуулсан туслахууд	Улс төрийн намууд	Газар
11 сар-2012	Газар шилжэлт	Үүс үүрхэй	Орон нутгийн захирал байгуулсан туслахууд	Мэргэжлийн Хэлэлцэх Газар	Улс төрийн намууд
4 сар-2011	Газар шилжэлт	Үүс үүрхэй	Шүүх	Газар	Улс төрийн намууд
9 сар-2010	Газар шилжэлт	Үүс үүрхэй	Шүүх	Газар	Улс төрийн намууд

3 сар-2010	Газар ашиглалт	Үүл уурхай	Улс төрийн нэмүүд	Гааль	УИХ/Хууль тогтоох байгууллага
9 сар-2009	Газар ашиглалт	Шүүх	Цагдаагийн байгууллага	Прокурор	Үүл уурхай
3 сар-2009	Газар ашиглалт	Үүл уурхай	Шүүх	Гааль	Прокурор
9 сар-2008	Газар ашиглалт	Үүл уурхай	Гааль	Шүүх	Прокурор
3 сар-2008	Газар ашиглалт	Үүл уурхай	Гааль	Бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээ	Шүүх
9 сар-2007	Газар ашиглалт	Үүл уурхай	Гааль	Бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээ	Шүүх
3 сар-2007	Газар ашиглалт	Гааль	Үүл уурхай	Шүүх	Бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээ
9 сар-2006	Газар ашиглалт	Гааль	Үүл уурхай	Шүүх	Цагдаагийн байгууллага
3 сар-2006	Газар ашиглалт	Гааль	Үүл уурхай	Шүүх	Цагдаагийн байгууллага

**Зураг 6.1:** Авлигад хамгийн их автсан байгууллагууд, (2017 оны 3 сар)

(1-Огт үгүй, 5 – Маш ихээр)



2006 оны 3 сараас 2014 оны 3 сар хүртэл хугацаанд хийгдсэн судалгаануудад авлигад хамгийн их автсан байгууллагаар тодорсон “Газрын алба”, “Уул уурхайн салбар”, “Улс төрийн намууд”-ын үзүүлэлт хэдэн жилийн өмнөхөөс өөрчлөгдөж, хэлбэлзсэн харагдаж байна (Зураг 6.2). Гэсэн хэдий ч 2015 оны 3 сараас хойш эдгээр 3 байгууллагын авлигад автсан байдлыг үнэлэх үзүүлэлт ижил түвшинд очсон байна.

**Зураг 6.2:** Авлигад хамгийн их автсан гурван салбар, байгууллага (2017 оны 3 сар)

Авлигад автсан бусад байгууллагын талаарх нээлттэй асуултад, оролцогчдын дийлэнх нь Барилгын салбар болон Төрийн өмчит компаниудыг нэрлэсэн байна (Зураг 6.3). Эдгээр байгууллага, салбарын талаар болон эдгээрийн авлигын түвшнийг 2018 оны хавар хийгдэх судалгаанд шалгах замаар судалгааны санал асуулгын хуудсандаа нэмж оруулна.

**Зураг 6.3:** Авлигад автсан бусад салбар, байгууллагууд (2017 оны 3 сар)  
(Судалгаанд оролцогчдын дурдсан тоо хэмжээ)


# 7 ХЭЭЛ ХАХУУЛЬ ХУВЬ ХҮНД



## 7. ХЭЭЛ ХАХУУЛЬ ХУВЬ ХҮНД

Өмнөх жилийн судалгааны үр дүнтэй харьцуулахад “авлига өгөхийг шаардахад хүмүүсийн гаргах хандлага” үл ялиг өөрчлөгдсөн байна. (Зураг 7.1) 2016 оны 3 сард судалгаанд оролцогчдын 45.1 хувь “авлига өгөхийг шаардсан тохиолдолд хээл хахууль өгөхгүй” гэж хариулж байсан бол 2017 оны 3 сард энэ тоо 38.8 хувь болж буурсан байна. Үүнээс гадна, 2016 оны 3 сард оролцогчдын 13.4 хувь хахууль өгөлгүйгээр асуудлыг шийдвэрлэхэд туслах хэн нэгнийг хайхыг илүүд үзэж байсан бол 2017 оны 3 сард 18.9 хувь нь ингэж хариулсан байна. Хэрэв мөнгө байвал хахууль өгөхөд бэлэн гэж хариулсан хүмүүсийн тоонд онцын өөрчлөлт гараагүй байна. Ерөнхийдөө энэ талаарх 2017 оны 3 сарын нөхцөл байдал 2015 оны 3 сарынхтай нилээд ижил байгаа нь ажиглагдаж байна. 2016 онд Монгол Улсын Их Хурлын сонгууль болсонтой холбоотойгоор 2016 оны 3 сарын судалгаанд улс төрийн орчин нөхцөл нөлөөлсөн байх магадлалтай.

**Зураг 7.1:** Хэрвээ танаас төрийн байгууллагын ажилтан эсвэл хувийн хэвшлийн ажилтан хээл хахууль өгөхийг шүүд шаардсан тохиолдолд та юу хийх вэ?



Хээл хахууль өгөх шаардлагатай тулгарахад нийгмийн ялгаатай бүлгүүд өөр өөр хариу үйлдэл үзүүлдэг болох нь ажиглагдсан. 2017 оны 3 сарын судалгааг хүйсээр нь ялгаж хүснэгтэнд тусгасан. (Зураг 10.2). Үүнээс харахад эмэгтэй хүмүүс эрэгтэйчүүдийг бодвол авлигыг илүүтэйгээр хүлээн зөвшөөрдөггүй байна. Хээл хахууль өгөхийг шаардсан үед эмэгтэйчүүдийн 41.1 хувь, эрэгтэйчүүдийн гуравны нэг орчим хувь нь (36.3 хувь) “Хээл хахууль өгөхгүй” гэж хариулсан байна. Түүнчлэн таван эрэгтэй тутмын нэг нь (22.8 хувь) хахууль өгөхөд бэлэн гэж хариулсан бол таван эмэгтэй тутмын нэгээс бага хувь нь авлига өгнө гэж хариулжээ (17.6 хувь).



**Зураг 7.2:** Хэрвээ танаас төрийн байгууллагын эсвэл хувийн хэвшлийн ажилтан хээл хахууль өгөхийг шүүд шаардвал та юу хийх вэ? (2017 оны 3 сар, хүйсээр)



Үүнтэй ижил үр дүнг насны ангилалаар хүснэгтэнд оруулаад харахад (Зураг 7.3) нас насанд авлига өгөх хандлага буурсан байна. Хамгийн их авлига өгөх хандлагатай бүлэгт 25-29 насныхан байгаа бөгөөд энэ насны бүлгийнхний дөнгөж 28 хувь нь авлига өгөхгүй гэж хариулсан байхад 60 болон түүнээс дээш насны хүмүүсийн 53.4 хувь нь авлига өгөхгүй гэж үзжээ.


**Зураг 7.3:** Хэрвээ танаас төрийн байгууллагын эсвэл хувийн хэвшлийн ажилтан хээл хахууль өгөхийг шүүд шаардсан тохиолдолд та юу хийх вэ? (2017 оны 3 сар, насны бүлгээр)






Авлигын талаарх мэдээллийг аль байгууллагад өгөх вэ гэсэн асуултанд нийт оролцогчдын талаас илүү хувь нь Авлигатай Тэмцэх Газарт гэж хариулсан байна (Зураг 7.4).

**Зураг 7.4: Хэрэв мэдээлэл өгөх бол хаана хандах вэ?**




Ашиг сонирхлын зөрчил авлигатай салшгүй холбоотой байдаг. Өмнөх жилтэй харьцуулахад эдгээр зөрчлийг мэдэгдэх хандлага өссөн байна. 2016 оны 3 сард оролцогчдын 47% хувь нь “энэ талаар мэдэгдэнэ” гэж хариулж байсан бол 2017 оны 3 сард оролцогчдын 55.5 хувь нь “энэ талаарх зөрчлийг холбогдох газарт нь мэдэгдэнэ” гэж хариулжээ. (Зураг 7.5). Түүнчлэн, төрийн албан хаагч ба ашиг сонирхлын зөрчлийн талаарх асуултанд (Зураг 7.6) судалгаанд оролцогчдын бараг тэн хагас нь төрийн албан хаагчид “Зарим тохиолдолд” ашиг сонирхлын зөрчил гаргадаг (48.8 хувь), харин дөрөвний нэг хувь нь төрийн албан хаагчид ашиг сонирхлын зөрчил “Байнга” гаргадаг гэж хариулсан байна (24.6 хувь). Авлигын талаарх мэдээллийг ихэнх оролцогчид түхэйн байгууллагын удирдлагад мэдэгдэнэ (37.5 хувь) гэж хариулсан байхад Авлигатай Тэмцэх Газарт мэдээлнэ гэсэн сонголт (21.6 хувь) хоёрдугаарт орсон байна (Зураг 7.7).


**Зураг 7.5:** Хэрвээ та ашиг сонирхолын зөрчлийн талаар мэдвэл аль нэг газарт мэдэгдэх үү?



**Зураг 7.6:** Таны бодлоор төрийн байгууллагын ажилтнууд хэр их ашиг сонирхолын зөрчилд ордог вэ?



**Зураг 7.7:** Хэрэв та ашиг сонирхолын зөрчлийг мэдэгдэх бол хаана хандах вэ? 2017 оны 3 сар



# 8 ШУДАРГА ХАНДЛАГЫН ХҮЛЭЭЛТ



## 8. ШУДАРГА ХАНДЛАГЫН ХҮЛЭЭЛТ

Байгууллагуудын зүгээс шударга хандана гэсэн хүмүүсийн хүлээлт ерөнхийдөө маш доогуур байсан хэдий ч энэ хандлага жилээс жилд бага багаар эерэг чигт өөрчлөгдөж байна. Байгууллага шударга хандана гэсэн хүлээлт 2010 оноос хойш бүх байгууллагуудад өссөн. (Зураг 11.1-ээс Зураг 11.6 хүртэл). Энэ нь Монголын байгууллагуудад хөгжил дэвшил гарч буйн нэг илрэл байж болох юм. Шударга хандана гэсэн хүлээлт өндөр байх нь олон нийтийн зүгээс системд итгэх итгэл нэмэгдэхэд нөлөөлж байна. Гэсэн хэдий ч энэхүү итгэлцлийн түвшин эдгээр байгууллагуудын авлигын түвшинтэй холбоогүй үзүүлэлт юм. Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь “ Асуудлыг шийдвэрлэх түгээмэл арга хэрэгсэл бол авлига юм” гэдгийг хүлээн зөвшөөрч буй нь иргэд тухайн байгууллагыг хэрхэн дүгнэдгийг илэрхийлж байна. (Зураг 2.3). Шударга хандана гэсэн хүлээлттэй хүмүүсийн тоо бага багаар өсөж байгаа нь тэдний итгэлцлийн шалгуур үзүүлэлт бага зэрэг ялгаатай илтгэж байна. Энэ нь үйлчилгээ болон харилцаа сайжирч байгаатай холбоотой байх магадлалтай. “Орон нутгийн засаг захиргаа, удирдлагын түвшинд шударга хандана” гэсэн хүлээлт хамгийн өндөр хувьтай гарсан байна (Зураг 8.5).

Шударга хандлагын хүлээлт салбар бүрт дараах байдлаар өссөн байна:

- ✔ Боловсролын салбарт + 17 хувь (2010 оны 3 сараас хойш)
- ✔ Эрүүл мэндийн салбарт + 17% хувь (2010 оны 3 сараас хойш)
- ✔ Шүүхийн тогтолцооны түвшинд + 9.3 хувь (2010 оны 3 сараас хойш)
- ✔ Хууль сахиулах салбарт + 9.3 хувь (2010 оны 3 сараас хойш)
- ✔ Орон нутгийн засаг захиргаа, удирдлагын түвшинд +18% хувь (2012 оны 11 сараас хойш)
- ✔ Засгийн Газрын түвшинд + 13.3 хувь (2012 оны 11 сараас хойш)

Эдгээр үр дүнг СМС-ийн Улс Төрийн Барометрийн үзүүлэлттэй харьцуулбал (Хүснэгт 8.1 болон 8.2), хэдийгээр Ерөнхийлөгч болон Улсын Их Хуралд итгэх итгэл буурсан ч орон нутгийн Засаг захиргаа болон Шүүхийн тогтолцоонд итгэх итгэл 2010 оноос хойш ихээхэн өссөн байна. Харин Засгийн Газраас хүлээх шударга хандлага болон авлигын үзүүлэлт доогуур үзүүлэлттэй хэвээр байна (Зураг 8.6 болон Хүснэгт 6.1-ийг харьцуулж харна уу).


2017 оны 3 сарын судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн 54.9 хувь, эрэгтэйчүүдийн 49.5 хувь боловсролын салбарыг шударга гэж хариулсан байхад эрэгтэй хүмүүс эмэгтэйчүүдээс илүүтэйгээр эрүүл мэндийн салбарыг шударга гэж дүгнэсэн байна (эрэгтэйчүүд 48.1 хувь, эмэгтэй хүмүүс 46.5 хувь). Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь хууль сахиулах болон шүүхийн тогтолцоог шударга бус, харин орон нутгийн засаг захиргааг шударга гэж үзсэн байна (Зураг 8.7).

**Хүснэгт 8-1: Төрийн байгууллагуудад итгэх итгэл, 2017 оны 3 сар (Эх сурвалж: СМС Улс төрийн барометр)**

Та төрийн байгууллагуудад хэр их итгэдэг вэ? (Үндэсний хэмжээнд, 2017 оны 3 сар)						
	Ерөнхийлөгч	Улсын Их Хурал	Шүүхийн тогтолцоо	Засгийн газар	Улс төрийн намууд	Иргэний нийгэм
Их итгэдэг	15.3	13.5	16.0	24.4	4.1	12.5
Итгэдэг	26.5	37.9	36.9	47.8	29.2	37.3
Бараг итгэдэггүй	25.5	28.3	25.9	19.0	35.1	26.3
Огт итгэдэггүй	28.6	16.9	16.3	6.5	25.5	14.9
(Хариулаагүй)	0.1	0.2	0.3	0.4	0.3	0.3
(Мэдэхгүй)	4.0	3.2	4.7	1.8	5.8	8.8


**Хүснэгт 8-2: Төрийн байгууллагуудад итгэх итгэл, 2010 оны 4 сар (Эх сурвалж: СМС Улс төрийн барометр)**

Төрийн байгууллагуудад итгэх итгэл (Үндэсний хэмжээнд, 2010 оны 4 сар)						
	Ерөнхийлөгч	Улсын Их Хурал	Шүүхийн тогтолцоо	Засгийн газар	Улс төрийн намууд	Иргэний нийгэм
Их итгэдэг	22.7	11.3	10.0	19.5	5.5	16.3
Итгэдэг	34.0	32.6	27.5	39.1	26.4	38.2
Бараг итгэдэггүй	20.2	29.1	28.3	25.1	30.3	19.6
Огт итгэдэггүй	17.7	22.3	28.3	12.8	30.2	17.5
(Хариулаагүй)	1.3	1.3	1.0	1.1	1.3	1.2
(Мэдэхгүй)	4.3	3.6	4.9	2.4	6.3	7.3


**Зураг 8.1: Шударга хандлага: Боловсролын салбар**



Зураг 8.2: Шударга хандлага: Эрүүл мэндийн салбар




Зураг 8.3: Шударга хандлага: Шүүхийн тогтолцоо







**Зураг 8.4: Шударга хандлага: Хууль сахиулах байгууллага**




**Зураг 8.5: Шударга хандлага: Орон нутгийн захиргаа**



Зураг 8.6: Шударга хандлага: Засгийн Газар



Зураг 8.7: Шударга хандлага (хүйсээр)



# 9 2017 ОНЫ СОНГУУЛИЙН ИЛ ТОД, ШУДАРГА БАЙДАЛ



## 9. 2017 ОНЫ СОНГУУЛИЙН ИЛ ТОД, ШУДАРГА БАЙДАЛ


2017 оны Ерөнхийлөгчийн Сонгуулийн ил тод, шударга байдлын талаарх таамаглал нь (Зураг 9.1-9.5) Улсын Их Хурлын 2016 оны сонгуулийн үеийн таамаглалтай ойролцоо байлаа. (2016 SPEAK тайлан).

Судалгаанд оролцогч таван хүн тутмын нэг нь сонгуулийн бэлтгэл ажил огт ил тод биш, шударга бус байх болов уу? гэж хариулсан. Гэсэн ч сонгуулийн санхүүжилтийн талаарх асуултанд нийт оролцогчдын ихэнх нь “мэдэхгүй” гэж (244 хувь) хариулсан нь анхаарал татаж байна (Зураг 9.2). Түүнчлэн оролцогчдын хамгийн өндөр хувь буюу 38 хувь нь сонгуулийн санхүүжилт огт ил тод биш, шударга бус болох болно гэж хариулжээ.


Харин сонгуулийн сурталчилгаа буюу компани ажлын ил тод, шударга байдлын хувьд харьцангуй сайн хүлээлттэй байв. Таван оролцогч тутмын нэг нь сонгуулийн сурталчилгааны ил тод, шударга байдлыг “Маш сайн” байх болно гэж хариулсан байна (21 хувь) (Зураг 9.3).

Улсын Их Хурлын 2016 оны сонгуулийн санал тоололт болон үр дүнг танилцуулах үйл явц харьцангуй тайван, хэвийн явагдсан тул 2017 оны 3 сарын судалгааны үр дүнгээр сонгуулийн энэ үе шат ил тод, шударга явагдана гэсэн хүлээлтэд нөлөөлсөн байна (Зураг 9.4 – Зураг 8.5).


**Зураг 9.1:** Сонгуулийн бэлтгэл, Жишээ нь: Сонгогчдыг бүртгэх, сонгуулийн хороод болон ажилтнуудыг бэлтгэх, гадаад дотоодын ажиглагчдыг оролцуулах гэх мэт




Зураг 9.2: Сонгуулийн санхүүжилт



Зураг 9.3: Сонгуулийн сурталчилгаа



Зураг 9.4: Санал хураах байранд саналыг тоолох үйл явц




Зураг 9.5: СЕХ-ноос сонгуулийн дүнг нэгтгэж, олон нийтэд танилцуулах үе





Эмэгтэйчүүд гол төлөв “мэдэхгүй” гэж хариулдаг бол сүүлийн гурван жилийн хугацаанд сонгуулийн үйл явцын авлигын талаарх асуултанд мэдэхгүй гэсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тоо ерөнхийдөө буурсан байна.

**Зураг 9.6:** Сонгуулийн шударга байдал: хариулаагүй, хүйсээр







# 10 АВЛИГЫН ШАЛТГААН



## 10. АВЛИГЫН ШАЛТГААН

Судалгааны үр дүнд оролцогчид дараах 7 хүчин зүйлсийг үндэслэж авлигын цаад шалтааныг тодорхойлсон байна. Үүнд:

- ☑ Төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үр чадвар муу
- ☑ Улс төрийн удирдах дээд албан тушаалтнууд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэлгүй
- ☑ Улс төрийн удирдах дээд албан тушаалтнууд авлигын асуудлыг Орон нутгийн түвшинд хянах хүсэл эрмэлзэлгүй
- ☑ Хүндрэлтэй асуудлыг хууль дүрмийн дагуу бус хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл болсон
- ☑ Хууль сахиулах байгууллагын хүрээнд авлига газар авсан
- ☑ Олон нийт идэвхгүй
- ☑ Авлигатай тэмцэх хууль тогтоомж, хүлээлгэх ял шийтгэл боловсронгуй биш

“Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад улс орны түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй”, мөн “Хүндрэлтэй асуудлыг хууль дүрмийн дагуу бус хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл болсон” гэсэн хариултууд хамгийн өндөр хувийг эзэлсэн байна (Зураг 10.1).

Түүнчлэн, хамгийн өндөр үзүүлэлтүүд Улс төрийн өндөр албан тушаалтнуудтай холбогдсон байна. Үүний дараа хувь хүний хандлагатай холбоотой шалтгаануудыг нэрлэсэн байна. “Хууль сахиулах байгууллагын хүрээнд авлига газар авсан”, “Авлигатай тэмцэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, хүлээлгэх ял шийтгэл нь боловсронгуй биш” гэсэн хариултууд удаалжээ. Харин “Төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үр чадвар муу” гэсэн санал хамгийн бага хувийг эзэлж байна.


**Зураг 10.1: Авлигын үндсэн шалтгаан (дундаж үтгэл)**




2017 оны 3 сард хийгдсэн судалгааны үр дүнг өмнөх оныхтой харьцуулбал бүхий л үзүүлэлтүүдэд томоохон өөрчлөлт гарсныг харж болно (Зураг 10.2 – 10.8). Сонголтот 7 хариултын 6-д (дор дурдсан) нь “Их хэмжээгээр” гэж хариулсан оролцогчдын тоо нилээд өссөн байна.

- ✔ Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад Улс орны түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй
- ✔ Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад Орон нутгийн түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй
- ✔ Хүндрэлтэй асуудлыг хууль дүрмийн дагуу бус хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл болсон
- ✔ Хууль сахиулах байгууллагын хүрээнд авлига газар авсан
- ✔ Олон нийт идэвхгүй
- ✔ Авлигатай тэмцэх хууль тогтоомж, хүлээлгэх ял шийтгэл нь боловсронгуй биш


**Зураг 10.2: Төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үр чадвар муу (Авлигын шалтгаан)**




**Зураг 10.3:** Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад улс орны түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй (Авлигын шалтгаан)




**Зураг 10.4:** Улс төрийн удирдах дээд албан тушаалтнуудад орон нутгийн түвшинд авлигын асуудлыг хянах хүсэл эрмэлзэл байхгүй (Авлигын шалтгаан)





**Зураг 10.5:** Хүндрэлтэй асуудлыг хууль дүрмийн дагуу бус хээл хахуулиар шийдвэрлэх арга түгээмэл болсон (Авлигын шалтгаан)



**Зураг 10.6:** Хууль сахиулах байгууллагын хүрээнд авлига газар авсан





**Зураг 10.7: Олон нийтийн идэвхгүй байдал (Авлигын шалтгаан)****Зураг 10.8: Авлигатай тэмцэхэд чиглэгдсэн хууль тогтоомж, хүлээлгэх ял шийтгэл боловсронгуй биш (Авлигын шалтгаан)**

# 11 АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ




## 11. АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

2014-2015 оны судалгааны үр дүнгээс авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх ёстойг тодорхой харж болно. (Зураг 11.1). Оролцогчид дараах сонголтод үнэлгээ өгсөн. Үүнд:


- ☑ Хүчтэй арга хэмжээ авах, хатуу шийтгэл оногдуулах
- ☑ Хуулиа тогтвортой хэрэгжүүлэх
- ☑ Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх
- ☑ Засаг захиргааны шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, ил тод болгох
- ☑ Төрийн зүгээс захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах
- ☑ Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллагуудын зүгээс тавих хяналтыг сайжруулах
- ☑ Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх

“Хүчтэй арга хэмжээ авах, хатуу шийтгэл оногдуулах” болон “Хуулиа тогтвортой хэрэгжүүлэх” гэсэн хариулт хамгийн өндөр санал авсан байна. 2017 оны 3 сард нийт оролцогчдын 28.5 хувь нь “Хүчтэй арга хэмжээ авах, хатуу шийтгэл оногдуулах” гэж хариулсан бол 20.1 хувь нь “Хуулиа тогтвортой хэрэгжүүлэх” гэж хариулсан байна.

**Зураг 11.1: Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх ёстой вэ?**




**Зураг 11.2:** Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх ёстой вэ? 2017 оны 3 сар




Өмнөх жилүүдийн судалгааны үр дүнтэй харьцуулахад авлигын хэргээр ял шийтгэл оногдуулсан талаарх хүмүүсийн мэдээлэл 2017 оны 3 сард хамгийн доогуур үзүүлэлттэй байна. Албан тушаалтан авлигын хэргээр шийтгүүлсэн талаар сонсож, мэдсэн гэж оролцогчдын дөнгөж 29 хувь хариулсан байна (Зураг 11.3). Түүнчлэн, авлигын талаар мэдээлэл өгөх утас ажилладаг талаар ихэнх оролцогчид мэдэхгүй байв. (Зураг 11.4). 2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын хорь хүрэхгүй хувь нь ийм утас ажилладаг гэдгийг мэднэ гэж хариулсан байна.

Авлигатай Тэмцэх Газар хувь хүний нэр, хувийн мэдээллийг нууцалсан хэлбэрээр авлигын талаар мэдээлэл хүлээн авдаг болвол авлигын хэргийг мэдээлнэ гэж хариулсан хүмүүсийн хандлага судалгааг анх хийж эхэлснээс хойш бараг өөрчлөгдөөгүй (Зураг 11.5). Энэ удаа судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь ийм нөхцөл бүрдвэл авлигын хэргийг мэдээлнэ гэж хариулжээ.

**Зураг 11.3:** Та аль нэг албан тушаалтан авлигын гэмт хэрэгт шийтгүүлсэн тухай сонссон үү?**Зураг 11.4:** Авлигатай Тэмцэх Газарт авлигыг мэдээлэх утас ажиллаж байгааг та мэдэх үү?

**Зураг 11.5:** Хэрвээ Авлигатай Тэмцэх Газар нэр хаяггүй мэдээлэл хүлээж авна гэвэл та авлигын талаар мэдээлэл өгөх үү?








# 12 АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ



## 12. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ

“2017 оны 3 сарын байдлаар Авлигатай тэмцэх газар авлигатай тэмцэх тэмцлийг удирдан зохион байгуулах хэрэгтэй гэсэн хандлага хэвээр үргэлжилсэн байна (Зураг 12.1). Хэдийгээр энэ удаад мөн тэргүүлсэн ч хүмүүсийн энэ хандлага 2012 оны 11 с араас буурсан байна. АТГ-ын энэ үзүүлэлт 2012 оны 11 сард 44.4 хувь байсан бол 2017 оны 3 сард 35.3 болж буурсан байна. Энэ бүүралт нь ЗГ-аас хүлээх авлигатай тэмцэх үүрэг оролцооны хүлээлт өндөр байсантай холбоотой буюу 2012 оны 11 сард энэ 13.1 хувь байсан бол 2017 оны 3 сард 17.1 хувь болсон байна. Мөн судалгаанд оролцогчдын “Хууль сахиулах байгууллага” гэсэн сонголт үрт хугацаанд хэлбэлзэж байсан ч 2017 оны 3 сарын байдлаар 10 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг 12.1:** Таны бодлоор Авлигатай Тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (Эхний 5 үзүүлэлт)




Одоогийн Засгийн Газар авлигатай тэмцэхэд өмнөх Засгийн Газраас илүү сайн ажиллана гэсэн хандлагад бага зэргийн эерэг өөрчлөлт гарсан хэдий ч сөрөг хандлага зонхилж байна. 2016 оны 3 сард нийт оролцогчдын 10 хүрэхгүй хувь нь (8 хувь) Ч.Сайханбилэгийн удирдаж байсан Засгийн Газар авлигатай тэмцэх үйл ажиллагаанд Н.Алтанхуягийн удирдаж байсан өмнөх Засгийн Газраас илүү сайн ажиллана гэсэн хүлээлттэй байсан байна. 2017 оны 3 сард оролцогчдын арав гаруйхан хувь буюу 11 хувь одоогийн ерөнхий сайд Ж.Эрдэнэбат авлигатай тэмцэх үйл ажиллагааг өмнөх ерөнхий сайд Ч.Сайханбилэгээс илүү сайн зохион байгуулна гэж хариулсан байна. Бага зэргийн хэлбэлзлийг үл тооцвол, оролцогчдын 20 орчим хувь нь “мэдэхгүй”, харин бараг тэн хагас нь өөрчлөлт гарахгүй гэж хариулсан байна.

**Зураг 12.2:** Таны бодлоор одоогийн Засгийн Газар өмнөх Засгийн Газартай харьцуулахад авлигын эсрэг тэмцэнэ гэж бодож байна? (2010 – 2017 он)




**Зураг 12.3:** Таны бодлоор одоогийн Засгийн Газар өмнөх Засгийн Газартай харьцуулахад авлигатай тэмцэх вэ? (2006 – 2017 он)



2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь Шилэн дансны тухай хуулийг авлигатай тэмцэхэд “Маш чухал” ач холбогдолтой хэрэгсэл гэж хариулсан байна (Зураг 12.4-т 64.6 хувь). Гэсэн хэдий ч жил жилийн судалгааны үр дүнгээс харахад энэ хуулийг үр дүнгүй гэж үзэх оролцогчдын тоо өсөх хандлагатай байна. 2016 оны 3 сард оролцогчдын 26.5 хувь нь энэ хуулийг авлигатай тэмцэхэд “Үр дүнгүй” эсвэл “Үр дүн маш бага” гэж хариулж байсан бол 2017 оны 3 сард энэ тоо бараг 2 дахин өсөж 41.5 хувьд хүрсэн байна (Зураг 12.5).

**Зураг 12.4:** Шилэн дансны тухай хууль хэр ач холбогдолтой вэ?



**Зураг 12.5: Шилэн дансны тухай хууль нь хэр үр дүнтэй байна вэ?**


Авлигад нөлөөлөх хүний хүчин зүйлийг бууруулахын тулд шинэ техник, технологийг ашиглах тал дээр хүмүүсийн хандлага өөрчлөгдөж байгаа нь ажиглагдсан (Зураг 12.6 – Зураг 12.7). 2017 оны 3 сард оролцогчдын ихэнхи хувь нь (83 хувь) Төрийн үйлчилгээний цахим машин, Нэг цонхны үйлчилгээ гэх мэт шинэ технологийг “Маш чухал”, “Нилээд чухал” ач холбогдолтой гэж үзсэн байна. Түүнчлэн 2016 оны 3 сард оролцогчдын 56.8 хувь нь эдгээр шинэ технологийг авлигатай тэмцэхэд “Маш чухал”, “Нилээд чухал” үр дүнтэй гэж хариулж байсан бол 2017 оны 3 сард 66.8 хувь нь ингэж хариулсан байна.



**Зураг 12.6:** Төрийн үйлчилгээний цахим машин, Нэг цонхны үйлчилгээ гэх мэт нь хэр чухал байна вэ?



**Зураг 12.7:** Төрийн үйлчилгээний цахим машин, Нэг цонхны үйлчилгээ гэх мэт нь хэр үр дүнтэй байна вэ?




2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын 64.9 хувь нь төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг “Маш чухал”, “Нилээд чухал” ач холбогдолтой гэж дүгнэсэн байна. Гэсэн хэдий ч үүнийг үр дүнтэй гэж үзсэн оролцогчдын тоо 2016 оны 3 сард 33.5 хувь байснаас 2017 оны 3 сард 31.5 хувь болж бууржээ. (Зураг 12.9).

**Зураг 12.8:** Төрийн албан хаагчдаас тогтмол гаргуулж авдаг хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг нь хэр ач холбогдолтой байна вэ?



**Зураг 12.9:** Төрийн албан хаагчдаас тогтмол гаргуулж авдаг хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг нь хэр үр дүнтэй байна вэ?



Авлигатай тэмцэх санал, санаачилгад Нэг цонхны үйлчилгээг маш чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 12.10 – Зураг 12.11). 2017 оны 3 сард оролцогчдын дийлэнх хувь нь үүнийг “Маш чухал”, “Нилээд чухал” ач холбогдолтой (84 хувь), мөн “Маш их”, “Нилээд их” үр дүнтэй (70.5 хувь) гэж хариулсан байна.

**Зураг 12.10:** Нэг цонхны үйлчилгээний төвүүд хэр ач холбогдолтой байна вэ? (2017 оны 3 сар)



**Зураг 12.11:** Нэг цонхны үйлчилгээний төвүүд хэр үр дүнтэй байна вэ? (2017 оны 3 сар)



Авлигатай тэмцэх ажлын санал, санаачилгын талаарх сүүлийн үеийн мэдээлэл хүмүүст тэр бүр хүрч чадаагүй байна. Судалгаанд оролцогчдын дөнгөж 29 хувь нь 2016 оны 11 сард УИХ-аас Авлигатай Тэмцэх Үндэсний Хөтөлбөр батлагдсан гэдгийг мэдэж байсан.

**Зураг 12.12:** 2016 оны 11 сард Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсаныг та мэдэх үү?



# 13 АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР







## 13. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

2013 оны 9 сараас хойш АТГ-ын үйл ажиллагааны үнэлгээ тогтмол бүүрсан байна (Зураг 13.1). 2013 оны 9 сард АТГ-ын ажлыг маш сайн гэж үзсэн хүмүүсийн тоо олон жилийн судалгаанаас хамгийн өндөр байсан бөгөөд нийт оролцогчдын дөрөвний нэг нь (24.8 хувь) ийнхүү хариулсан байхад энэ тоо тогтмол бүүрсаар 2017 оны 3 сарын судалгаанд оролцогчдын 10 хүрэхгүй хувь нь (7.6 хувь) АТГ-г сайн ажилладаг гэж дүгнэсэн байна. 2017 оны 3 сарын судалгаанд оролцогчдын 8.8 хувь АТГ-ын үйл ажиллагааг их сайн/харьцангуй сайн, 33.5 хувь нь сайн ч биш, мүү ч биш, харин 49.2 хувь нь тааруухан буюу мүү гэж үзсэн байна (Зураг 13.2).

**Зураг 13.1: Авлигатай Тэмцэх Газрын үйл ажиллагааг та хэрхэн үнэлж байна вэ?**




**Зураг 13.2:** Авлигатай Тэмцэх Газрын үйл ажиллагааг та хэрхэн үнэлж байна вэ? 2017 оны 3 сар




Үүнээс гадна оролцогчдын итгэлцлийн түвшин буурсан үзүүлэлт харагдаж байна (Зураг 13.3). 2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын 27.6 хувь нь АТГ-т итгэдэг, 65.8 хувь нь итгэдэггүй гэж хариулжээ (Зураг 13.4). Иргэдийн АТГ-ын улс төрийн хараат бус байдалд итгэх итгэл 2014 оны 3 сараас эхлэн алдагдаж эхэлсэн байна (Зураг 13.5). 2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын дөнгөж 13.4 хувь АТГ-ыг улс төрийн хувьд хараат бус байдаг гэж хариулжээ.


Зураг 13.3: Авлигатай Тэмцэх Газарт та хэр зэрэг итгэдэг вэ?



**Зураг 13.4:** Авлигатай Тэмцэх Газарт Та хэр зэрэг итгэдэг вэ? 2017 оны 3 сар



**Зураг 13.5:** Та Авлигатай Тэмцэх Газар бие даасан, аль нэг улс төрийн хүчнээс хамааралгүй үйл ажиллагаа явуулж чаддаг гэдэгт итгэдэг үү?





# 14 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ





## 14. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

Авлигын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэхэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл чухал үүрэг гүйцэтгэдэг. Өрхийн түвшний авлигыг хүмүүсийн амьдралын туршлагаас ажиглаж болох бол дээд түвшний авлигын талаарх мэдээлэл ихэнх тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тардаг байна.


2012 оноос эхлэн хэвлэл мэдээллийн орчинд авлигын асуудлыг хөндөж тавих тал дээр томоохон өөрчлөлт гарч байгааг бид судалгааны үр дүнгүүдээс харж болно. Хэдийгээр Телевизүүд авлигын талаарх мэдээллээр хангадаг хамгийн том мэдээллийн хэрэгсэл хэвээр байгаа ч (2012 оны 11 сард нийт оролцогчдын 67.9 хувь, 2017 оны 3 сард 64.9 хувь), Интернет болон Нийгмийн цахим сүлжээний үүрэг жилээс жилд өсөх хандлагатай байна. Цахим орчин, Нийгмийн сүлжээг авлигын талаарх мэдээллийн эх сурвалж болгон ашиглаж байгаа хүмүүсийн тоо 2012 оны 11 сард 3.8 хувь байсан бол 2017 оны 3 сард 17.4 хувь болж өссөн байна. Энэ өсөлт хүмүүс хоорондын нийгмийн харилцаа, уламжлалт мэдээллийн хэлбэрээс цахим орчинд шилжиж, идэвхтэй болсонтой холбоотой.

2012 оны 11 сард хийгдсэн судалгаатай харьцуулахад 2017 оны судалгааны үр дүнд дараах мэдээллийн эх сурвалжуудын эзлэх хувь буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- ✓ Амнаас ам дамжиж: - 3.4 хувиар
- ✓ Найзууд / Хамаатан садан: - 3.7 хувиар
- ✓ Сонин, сэтгүүл: - 3.5 хувиар

**Зураг 14.1:** Авлигын талаарх голлох мэдээллийг Та аль эх сурвалжаас авдаг вэ?


(Зөвхөн нэг хариултыг сонгоно)



Оролцогчдын ихэнх нь телевизийн сүвгүүд дундаас TV9 телевизийг авлигын талаар хамгийн их мэдээлэл хүргэдэг гэж үзсэн байна. 2010 оны 3 сарын судалгаанд Монголын Үндэсний Телевизийг авлигын талаар хамгийн их мэдээлэл дамжуулдаг хэмээн хамгийн олон оролцогч буюу нийт оролцогчдын 31.8 хувь нь нэрлэж байсан бол 23.7 хувьтайгаар TV9 удаалж байсан байна. Харин 2012 оны 11 сараас хойш өөрчлөлт гарч TV9 телевиз өнөөг хүртэл энэ үзүүлэлтийг байнга тэргүүлж байна. 2017 оны 3 сард оролцогчдын 40.3 хувь нь TV9 телевизийг, 27.9 хувь нь Монголын Үндэсний Телевизийг авлигын талаарх мэдээллийн гол эх сурвалж гэж үзсэн байна.

Өмнөх судалгаануудад 25-р суваг маш дээгүүр байр эзэлж байсан. 2010 оны 3 сард оролцогчдын 22.6 хувь нь 25-р сүвгийг авлигын талаарх мэдээллийн 3 том эх сурвалжийн нэг хэмээн нэрлэж байжээ. Гэсэн хэдий ч энэ хандлага тогтмол бүүрсаар 2017 оны 3 сард судалгаанд оролцогчдын дөнгөж 3.3 хувь нь 25-р сүвгийг авлигын мэдээллийн эх сурвалж гэж хариулсан байна.


**Зураг 14.2:** Хэрэв телевизийн суваг мэдээллийн голлох эх сурвалж бол, авлигын талаар хамгийн их мэдээлдэг сүвгийг нэрлэнэ үү? (зөвхөн нэг хариултыг сонгоно)



Зургаан жилийн судалгааны үр дүнгээс харахад Интернет, Цахим орчны мэдээлэл түгээх үүрэг нэмэгдэж байгаа бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байна (Зураг 14.3).

Монгол Улсад нийгмийн сүлжээний эзлэх байр суурь өсөж байна. Авлигын асуудлыг мэдээлэх мэдээллийн цахим хуудсуудын үүрэг 2010 оны 3 сард 72 хувь байснаас 2017 оны 3 сард 49.2 хувь болтлоо буурсан байна. 2010 оны 3 сард оролцогчдын 17.3 хувь нь авлигыг мэдээлэхэд Facebook-ийг чухалчилж байсан бол 2017 оны 3 сард энэ тоо 44.9 хувь болон өсжээ.

**Зураг 14.3:** Хэрэв Интернет эсвэл Нийгмийн сүлжээ мэдээллийн голлох эх сурвалж бол, авлигын талаар хамгийн их мэдээлдэг эх сурвалжийг нэрлэнэ үү?




# 15 ХҮН АМ ЗҮЙ



## 15. ХҮН АМ ЗҮЙ

2017 оны 3 сарын судалгааны түүвэр оролцогчдын 47.1 хувь нь эрэгтэй, 52.9 хувь нь эмэгтэй байсан. Түүврийн насны бүлгийн хамгийн их хувийг 30 - 39 насныхан эзэлсэн. Харин боловсролын хувьд бүрэн дүнд боловсролтой иргэд хамгийн их хувийг эзэллээ (38.5 хувь). Судалгаанд оролцсон дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь үндэсний статистик мэдээнд байдгаас их буюу 33.4 хувийг эзэлж байсан нь судалгаанд түгээмэл тохиолддог юм. Хөдөлмөр эрхлэлтийн ангилалд “Бүтэн цагийн ажил хийдэг” бүлгийнхэн түүврийн хамгийн өндөр хувь буюу нийт оролцогчдын 34.1 хувийг эзэлсэн.

**Зураг 15.1:** Судалгаанд оролцогчид, хүйсээр, 2017 оны 3 сар




**Зураг 15.2:** Судалгаанд оролцогчид, насны бүлгээр, 2017 оны 3 сар



**Зураг 15.3:** Судалгаанд оролцогчид, боловсролын түвшинээр, 2017 оны 3 сар





**Зураг 15.4:** Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, 2017 оны 3 сар

## ХАВСРАЛТ: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааг бүтэцчилэгдсэн болон ганцаарчилсан ярилцлага авах хэлбэрээр 18 болон түүнээс дээш насны иргэдээс буюу насанд хүрэгчдээс авсан. Судалгаа нь санамсаргүй түүвэр болон магадлалын тархалтын аргачлалаар газар нутгийн бүлэглэлийн олон түвшнийг хамарсан.

Эхний шатанд Улаанбаатар хот болон Монгол Улсын дөрвөн бүс нутаг бүрээс хоёр хүртэлх аймгийг түүврийн аргаар сонгож авсан. Эдгээр аймгуудаас сумдыг, Улаанбаатар хотоос хороодыг санамсаргүй аргаар сонгосон. Аймаг болон сумын төвүүдийг түүвэрт зайлшгүй хамруулсан.

Хоёрдугаар шатанд Түүврийн Анхан Шатны Нэгжүүдийг (ТАШН) сонгосон. Улаанбаатар хотод ТАШН-үүдийг түүвэрлэгдсэн хороодоос, ниймгийн төвүүдэд засаг захиргааны хамгийн бага нэгж болох багуудаас сонгосон. Сумын төвүүдэд судалгааны багийн ахлагч өрхүүдийн бүлгийг тодорхойлсон бөгөөд ТАШН нь найман өрхөөс тогтсон бүлгүүдээс бүрдсэн.

Гуравдугаар шатанд эхлэх цэг болон өрхүүдийг тодорхойлсон. Улаанбаатар хотын орон сууцны хорооллуудын байшин болон хаалганы дугаар бүхий хаягийг судлаачдад өгсөн. Гэр хорооллуудад ажлын ахлагч г удамжны дугаар болон эхлэх цэгүүдийг судлаачдад хуваарилсан. Гэр хороололд судлаачид эхлэх цэгээс эхний өрхийг алгасаад хоёр дахь өрхөөс эхлэн ярилцлага авч, үүний дараа баруун гарын дүрмийг баримтлан гурав дахь өрх бүрийг сонгон ярилцлага хийсэн. Аймаг болон сумын төвүүдэд ахлагч эхлэх цэгийг тодорхойлсон ба судлаач баруун гарын дүрмээр гурав дахь өрх бүрийг сонгосон. Ярилцлагыг өрхийн тэргүүн эсвэл өрх гэрийн асуудлаар хамгийн их мэдлэгтэй хүнийг сонгож хийсэн.

Энэхүү тайланд 2017 оны 3 сарын 17-ны өдрөөс 2017 оны 4 сарын 7-ны хооронд хийсэн Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг тогтоох VI дахь судалгааны үр дүнг тусгав. Судалгаанд Улаанбаатар хотын найман дүүрэг, зургаан аймгийн 22 сумын нийт 1,360 айл өрхөөс бүрдсэн 170 анхан шатны нэгжүүд хамрагдсан.<sup>1</sup>

Түүврийн тархалтыг дараах хүснэгтэнд харуулав.

<sup>1</sup>Үр дүнгүүд 18 ба түүнээс дээш насны 1,360 насанд хүрэгчдээс авсан ганцаарчилсан ярилцлага дээр үндэслэгдсэн. Нийт улсын насанд хүрэгчдийн түүвэрт тулгуурласан үр дүнгийн хувьд түүврийн алдааны хязгаар  $\pm 1.6$  хувиас ( $p=10$  хувь бол,  $1-p=90$  хувь)  $\pm 2.6$  хувь ( $p=40$  хувь бол,  $1-p=60$  хувь) байх ба 95%-ийн итгэлийн түвшинд байна. Түүврийн алдаанаас гадна асуултын үг хэллэг болон санал аг уулга авах бодит хүндрэлүүд нь судалгааны гол үр дүнд алдаа болон нөлөөлөл үзүүлж болох юм.

**Хүснэгт А. Түүврийн тархалт**

Бүс	Хот/Аймаг	Дүүрэг/Сум	Судалгаа авсан өрхүүд
	Улаанбаатар		600
		Хан-Уул	72
		Баянзүрх	144
		Сүхбаатар	56
		Чингэлтэй	72
		Баянгол	88
		Сонгинохайрхан	136
		Налайх	16
		Багануур	16
	Аймагууд		760
Баруун бүс	Завхан		176
		Улиастай (төвийн сум)	80
		Тэлмэн	24
		Тосонцэнгэл	40
		Их-Уул	32
Хайнган бүс	Архангай		112
		Цэцэрлэг (төвийн сум)	48
		Өндөр-Улаан	32
		Цахир	32
	Өвөрхангай		144
		Арвайхээр (төвийн сум)	56
		Нарийнтээл	24
		Хайрхандулаан	24
		Өлзийт	20
		Баян-Өндөр	20
Төвийн бүс	Дорноговь		96
		Сайншанд (төвийн сум)	40
		Айраг	24
		Замийн үүд	32
	Төв		128
		Зуунмод (төвийн сум)	56
		Баян-Өнжүүл	24
		Баяндэлгэр	24
		Эрдэнэ	24
Зүүн бүс	Хэнтий		104
		Өндөрхаан (тэвийн сум)	47
		Баян-Овоо	24
		Жаргалтхаан	33
	Нийт		1360



